

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-32

1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ./ 4-26

2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./ 26-32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 05 дугаар сарын 20-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 07 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Лодойсамбуу, Г.Очирбат;

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Б.Жавхлан;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганмаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Б.Баярбаатар хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Д.Энхтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 7 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Ж.Хунан, Тамгын газрын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, мөн хэлтсийн ахлах референт Б.Мөнх-Эрдэнэ, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн референт Ц.Рэнцэндулам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн С.Дондов, Ж.Хунан нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Энхтуяа нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн С.Дондов, Ж.Хунан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Хэрлэн, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
15 цаг 07 минут.

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баярбаатар: Ёс зүйн дэгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны ирц хүрсэн тул ирцийг танилцуулж хурлыг нээе. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Доржзодовын Энхтуяа гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь, Болдын Жавхлан гишүүд маань чөлөө хүссэн. Даваасамбуугийн Ганмаа гишүүн эрүүл мэндийн чөлөөтэй. Чулуунбилигийн Лодойсамбуу, Ганбатын Очирбат нарын гишүүд маань орон нутагт ажиллаж байгаа учраас ингээд чөлөөтэй байна.

Ирц 58.3 хувь болсон тул өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудал 2 асуудал байна. Хуралдааны дарааллаар нэгдүгээрт “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх ёстой, хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Хоёрт, Монгол Улсын хүний эрх эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэлээр санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх ёстой байгаа. Хурал даргалагчийн хувьд би горимын санал гаргаж хэлэлцэх асуудлын дарааллын өөрчилж, Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг эхлээд нь хэлэлцүүлээд хоёрт, нь Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах тухай хоёр дахь хэлэлцүүлгийг хийх горимын саналыг оруулж байна.

Учир юу вэ гэвэл бусад Байнгын хороод маань бас яг энэ цаг мөчид хуралдаж энэ 26 оны төлөвлөгөөний хоёр дахь хэлэлцүүлгийг хийж байгаа. Байнгын хорооны хуралд асуудлаа танилцуулж байгаа ажлын хэсэг маань бас Байнгын хороодоор, бусад Байнгын хороодод орж байгаа учраас цаг хэмнэх үү үүднээс хэлэлцэх асуудлынхаа дарааллыг өөрчлөөд Хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлээ хэлэлцэх асуудлын эхэнд хэлэлцье гэсэн горимын саналыг оруулж байна.

Горимын санал оруулж байгаатай холбогдуулан санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Миний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор хэлэлцэх асуудалд дараалалд өөрчлөлт оруулъя гэсэн саналаар саналаар санал хураалт.

57.1 хувиар горимын санал дэмжигдсэн учраас хэлэлцэх асуудал өөрчлөлт орлоо.

Бадарчийн Хэрлэн гишүүн Доржзовдын Энхтуяа гишүүн нар протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Ажлын хэсгийг би та бүхэнд танилцуулна. Сангишаравын Дондов Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалал асуудал эрхэлсэн гишүүн, Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн, Галбаатарын Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний комиссын Тамгын газрын гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга, Балганы Мөн-Эрдэнэ Хүний эрхийн комиссын Үндэсний комиссын тамгын газрын Гомдол шалгалт, хяналт, шалгалтын хэлтсийн ахлах референт, Цогтбаярын Рэнцэндулам Хүний эрхийн Үндэсний комиссын Тамгын газрын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн референт гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Илтгэлийн 2 дугаар бүлэг болох Хүний эрх хамгаалагч, өмгөөлөгч сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал сэдвийг Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Сангишаравын Дондов танилцуулна.

Илтгэгчийн 5 дугаар бүлэг болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудлыг Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гэсэн Жаргалсайханы Хунан танилцуулна.

Илтгэлийн 6 дугаар бүлэг болох Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийг Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Сангишаравын Дондов нар тус тус танилцуулна. Нийтдээ 3 танилцуулга байгаа. 3 танилцуулгаа нэг мөр танилцуулга явсны дараагаар асуулт гишүүд асуулт асуух асуудалдаа орно. Ингээд Сангишаравын Дондов таныг урьж байна. Хэддүгээр микрофон? 4 номерын микрофон.

С.Дондов: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 7 дугаар зүйл, Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар хүний эрхийн хамгаалагчийн тухайн жилийн нөхцөл байдал ямар байгаа талаар илтгэлийг Улсын Их Хуралд хүргүүлдэг. Энэ дагуу энэ жил Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн нэг хэсэг болох хүний эрх хамгаалагчдын бүлэгт орох өмгөөлөгчдийн асуудал болон сэтгүүлчдийн өнөөгийн нөхцөл байдал гэсэн асуудлаар Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэлийн хоёр дахь бүлгийг бичсэн байгаа.

Тус илтгэлд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2021 онд батлагдан гарсан. Мөн 2022 оны 6 сараас эхлэн Хүний эрхийн Үндэсний комиссын дэргэд хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүү, мөн Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хяналт тавих үүргийг Хүний эрхийн Үндэсний комисс биелүүлж ирсэн. Энэ жил бол үндсэндээ Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэлийн хоёр дахь бүлэгт хүний эрх хамгаалагчийн олон улсын стандартад үнэлж үздэг, хүний эрх хамгаалагчдын бүрэлдэхүүнд ордог, хүний эрх хамгаалагч болох өмгөөлөгчдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ? Мөн сэтгүүлчдийн өнөөгийн эрх зүйн байдал ямар байна вэ гэсэн асуудлаар бэлтгэсэн байгаа. Ингээд та бүхэнд 2 асуудлаар товчхон мэдээлэл хийгээд тэгээд асуултад хариулах нь зөв гэж бодож байна.

Өмгөөлөгчдийн асуудлаар бол Монгол Улсад 2019 онд Өмгөөллийн тухай хууль шинээр батлагдан гарсан, мөн өмгөөллийн асуудлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар мөн зохицуулан ажиллаж байна. Монгол Улс Сивил жастис/civil justice/ буюу иргэний олон улсын байгууллагуудаас өгч байгаа үнэлгээгээр бол шударга ёсны индексээр бол 2020 оноос хойш үндсэндээ 142 орноос 50-60 орчим ийм дугаарт эрэмбэлэгдэж байгаа. Сэтгүүлчийн тухайд бол индексийн хувьд бол үнэхээр хангалтгүй байгаа.

Тийм учраас сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөний тухай хуулийг батлан гаргах, мөн өмгөөлөгчдийн тухайд бол Өмгөөллийн тухай хуулийг 2019 онд батлан гаргасан. Тийм учраас Өмгөөллийн тухай хуулийг бас тодорхой зарим зүйл, заалтуудад нь шинэчилж сайжруулах, өмгөөлөгчдийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд болон захиргаа, иргэний процессын үйл ажиллагаанд оролцохдоо мэтгэлцэх зарчмыг хуулийн дагуу хэрэгжүүлэх энэ бодит боломжуудыг олгох хууль зүйн шаардлага байна гэж ингэж үзсэн.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар өмгөөлөгчдийн хувьд бол мөн хүний эрх хамгаалагчийнх нь хувьд давхар эрх ашгийг нь хамгаалах хууль зүйн боломж нээгдсэн гэж үзэж болдог. Өмгөөлөгчдийн хамгийн их энэ илтгэлийг бичихэд өмгөөлөгчдийн асуудлыг илүү тод гаргахын тулд өмгөөлөгчдийн талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан гомдол, мөн өмгөөлөгчдийн 2019 оны хуулийг хийхэд зориулж хийсэн судалгаанууд, мөн түүнээс хойш ер нь шүүхээр өмгөөлөгчдийн болон сэтгүүлчдийн маргаантай асуудлыг хэрхэн шийдсэн бэ гэсэн энэ кэйсүүдэд тодорхой хэмжээний анализ хийж үзсэн.

Ингээд энэ гомдлууд болон кэйсүүдэд анализ хийсэн бусад судалгаанууд, мөн олон улсын хэмжээнд зайлшгүй харгалзаж үзвэл зохих ёстой стандартууд зэргийг үнэлж үзээд Хүний эрхийн Үндэсний комиссоос бол Улсын Их Хуралд өмгөөлөгчдийн талаар, өмгөөлөгч, сэтгүүлчдийн талаар бол үндсэндээ 16 саналыг бол оруулсан байгаа. Энэ саналд бол зайлшгүй бодлогын хэмжээнд шийдвэрлэвэл зохих ёстой чухал саналууд байгаа. Мөн явцын дунд зайлшгүй хэрэгжүүлбэл зохих ёстой саналууд байгаа гэж ингэж ангилсан.

Хүний эрх хамгаалагч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх баталгааг хангахын тулд хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдуулан хууль бусаар шалгах, халдашгүй байдлыг нь зөрчих явдал бол бас манайд гарч байна.

Тийм учраас өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг нь хангахын тулд олон улсын хуульчдын холбооноос баталгаажуулсан хуульчдын мэргэжлийн хариуцлагын дүрэм, мөн Хуульчдын холбооноос дагаж мөрддөг хуульчдын дагаж мөрдвөл зохих үүргийн зарчим гэсэн ийм чухал олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж ингэж үзсэн. Өмгөөллийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, бусад байдлаар нөлөөлсөн этгээдийн үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах, хуульд заасан хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй байна. Тийм учраас энэ асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

Мөн өмгөөлөгч цахим шүүх хуралд орохдоо үйлчлүүлэгчтэйгээ бодитой бүрэн харилцах боломж хязгаарлагдмал байна. Зарим тохиолдолд өмгөөлөгч битгий хэл шүүгдэгчийг ч биечлэн шүүх хуралд оролцуулалгүйгээр давж заалдах шатын шүүх хурлыг явуулж байгаа асуудал нь голдуу таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хорих арга хэмжээг өөрчлөх тухай өөрийнх нь гаргасан гомдлыг өөрийг нь болон өмгөөлөгчийг нь байхгүйгээр хэлэлцүүлж байгаа асуудал бол хүний эрхийг зөрчсөн үйлдэл байна гэж ингэж үзсэн.

Мөн үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах энэ бодит боломжийг бол олон улсын стандартад тов тодорхой зааж өгсөн. Өмгөөлөгч бол үйлчлүүлэгчтэйгээ хэнээс ч хараат бусаар ганцаарчлан уулзах энэ боломжийг бол хангах ёстой.

Гэтэл 461 дүгээр ангийн цагдан хорих төвд зарим тохиолдолд шүүгдэгч, өмгөөлөгч нарын зарим тохиолдолд яллагдагч тохиолдолд ч мөн ялгаагүй хоорондын харилцаа холбоог чагнах, тэдний хоорондоо ярилцаж тохирсон, мөн зарим шүүх хуралд болон мөрдөн байцаалтын шатад зайлшгүй залруулбал зохих ёстой, өөрт нь шаардлагатай хөнгөрүүлэн үзвэл зохих, хэрэгсэхгүй болговол зохих чухал үндэслэлүүдийг өмгөөлөгчийн тайлбарлаж байгаа энэ үндэслэлүүдийг нь сонсох ийм байдал бол гарч байгаа нь хүний эрхийн байдлыг дордуулж байна гэж ингэж үзсэн. Өмгөөлөгчийн ажил үүргээ гүйцэтгэх явцад түүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах тохиолдолд нийгмийн баталгааг хангах зохицуулалт Өмгөөллийн тухай хууль болон бусад хуулиудаар зохицуулаагүй байна. Энэ асуудлыг анхаарах нь зөв гэж үзсэн.

Өмгөөлөгчийг үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах, түүний байгаа газарт чөлөөтэй нэвтрэх эрхийг хэрэгжүүлэхэд хууль зөрчсөн хууль, хяналтын байгууллагын зарим дүрэм, журмыг хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна. Эсвэл хүчингүй болгох шаардлагатай байна гэж үзсэн.

Өмгөөлөгчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуульд заагаагүй аливаа шаардлага тавих нь процессын шатад өмгөөлөгч үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл, бэрхшээл учруулж байна. Өмгөөлөгчийн үйл ажиллагааг аливаа хэлбэрээр саатуулахыг оролдох, түүнд шүүх хурлыг тодорхой хэлбэрээр хойшлуулах гэх мэтийн ийм төвөгтэй байдлууд гарч байгааг бас анхаарч энэ асуудлыг нарийвчлан хуульчилж зохицуулах шаардлага байна гэж ингэж үзсэн. Өмгөөлөгчийн үйлчлүүлэгчийг төлөөлөх хуульд заасан бүрэн эрхийг төрийн болон төрийн бус оролцогчид хүлээн зөвшөөрч, хэрэгт хамааралтай баримт, лавлагаа, мэдээллийг хэрэгцээтэй байгаа үед нь зохих шаардлагад нь нийцүүлэн гарган өгөх үүргийн талаарх мэдлэг, ойлголтыг хуулийн этгээд болон төрийн байгууллагын зарим хүн ажилтнуудад мэдлэгийг нэмэгдүүлж, ойлголт, хандлагыг сайжруулах шаардлагатай байна гэсэн. Ийм үндсэн 7 саналыг өмгөөлөгчтэй холбогдуулж оруулсан байгаа.

Сэтгүүлч бол мөн хүний эрхийн хамгаалагчийн гол бүрэлдэхүүн хэсэгт орлодог. Мөн олон сэтгүүл сэтгүүлчид манай Хүний эрхийн Үндэсний комисст хандаж бидний үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх, нийтийн мэдэх эрхийг хангах энэ эрхийг зөрчиж байна. Тийм учраас сэтгүүлч хүний эрх хамгаалагчийн хувьд холбогдох дүгнэлтийг гаргаж өгөөч, энэ зөрчилтэй байгаа асуудлуудад хууль зүйн талаас нь анализ хийж өгөөч гэсэн ийм хүсэлтүүдийг бол бас тавьдаг, өргөдөл, гомдлоо ирүүлдэг. Мөн холбогдох сэтгүүлчдийн гаргасан өргөдөл, гомдлын дагуу Хүний эрхийн Үндэсний комиссоос тодорхой дүгнэлтүүд, мөн холбогдох газруудад

зөвлөмж, гишүүний зөвлөмж, шаардлага гэх мэтийн эрх зүйн актууд явагдаж хууль номын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.

Хүний эрхийн хамгаалагчийн гол хэсэг болох Сэтгүүлчийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 1998 онд батлагдаад өнөөдрийг хүртэл хэрэгжихдээ хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Тэр нь ч мөн олон улсын стандартуудаар мөн олон улсын олон улсаас Монгол Улсын сэтгүүлчдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ, хэвлэлийн эрх чөлөө ямар байна вэ гэдэг дээр маш муу дүгнэлт авсан байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийг нэн даруй батлах, мөн сэтгүүлчдийг аливаа зүйлээр ялгаварлан гадуурхах, мөн үл ялих зүйлээр шалтаглан цагдан хорих, эсвэл өндөр хорих ял оногдуулах гэх мэтийн ийм хууль бус үйл ажиллагаа явуулахгүй байх нь манай хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзсэн.

Мөн Эрүүгийн хуулийн 13, 14 дүгээр зүйл заалтад бол худал мэдээлэл тараах гэсэн энэ зүйл, заалтыг бол сэтгүүлчдэд хамааралгүй болгох асуудлыг бол бас илүү түлхүү анхаарах ёстой. Ингэхдээ сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, бололцоог нь хангахад энэ хуулийн зохицуулалтыг санаатай худал мэдээлэл тараах болон сэтгүүлч мэргэжлийн алдаа гаргах гэсэн энэ ялгаатай зүйлүүдийг нь нарийн зохицуулж өгөх асуудал бол чухал байна гэсэн ийм санал гаргасан байгаа.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад сэтгүүлчийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бас шаардлагад нийцүүлж зохицуулах шаардлагатай байна гэж ингэж үзсэн. Нийтийн ил тод мэдээллийн тухай хууль гээд их чухал хууль байдаг. Энэ хууль бол хэдийгээр.../минут дуусав./

Б.Баярбаатар: Цагийг нь сунгаад өгчихье. 4 номерын микрофон.

С.Дондов: Нийтийн ил тод мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудал дээр туйлын хангалтгүй байна. Тийм учраас сэтгүүлчдийн өөрийнх нь хүссэн өгөхгүй удаашруулах, хүнд суртал гаргах төрийн байгууллагын зарим ажилтнууд, мөн өөрийнх нь асуусан тодорхой тов тодорхой асуултыг гуйвуулж өөртөө ашигтай мэдээллүүдийг өгөх явдал нь сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх, нийтийн мэдээллийг хангах энэ боломжийг нь хязгаарлагдмал байдалд хүргэж байна гэж ингэж үзсэн.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагууд сэтгүүлчдийн аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрсдэл тохиолдсон үед үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хамгаалах агуулга бүхий заалт оруулах нь чухал юм гэсэн санал оруулсан. Мөн олон нийтэд үйлчлэх зорилго бүхий хамтын хэвлэл мэдээллийн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг байгуулж, түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох. Ингэхдээ төрөөс хараат хараат бусаар үйл ажиллагаа явуулах энэ зарчмыг баримталж, өрсөлдөөнд суурилсан шударга зохицуулалт хийх боломжийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулах нь зөв байна гэж үзсэн.

Редакцын хараат бус байдлыг хангасан зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн хууль тогтоомжоор зохицуулах, сэтгүүлч мэргэжлийн үйл

ажиллагааны хүрээнд ихэвчлэн холбогдож байгаа Иргэний хуулийн 21 дүгээр зүйл, заалтад заасан, 21.2 дахь хэсэгт заасан иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан этгээд түүнийхээ үнэн, зөвийг өөрөө нотлох гэсэн энэ заалтыг хэрвээ хариуцагч тал нь сэтгүүлч байгаа бол түүнд мэдээллийн эх сурвалжаа хамгаалах зорилгоор нотлох баримт гаргаж үүрэх өгөх үүргээс чөлөөлж болох агуулга бүхий заалт оруулах нь чухал байна гэсэн. Ийм нийтдээ 16 санал байгаа. Үүнээс бол зайлшгүй Улсын Их Хурлаар орж шийдүүлэх асуудал нь бол 6 асуудал байгаа. Явцын дунд хэрэгжүүлэх 7 санал байна гэж үзэж байгаа.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Дондов: Дондов гишүүн ээ та 6 дугаар бүлгийнхээ танилцуулгыг хийчих тэгээд дараа нь Хулан гишүүн танилцуулгаа хийчихье.

С.Дондов: 6 дугаар бүлэг дээр бол манай Энхболд гишүүн илүү шударгаар шүүлгэх асуудал, цагдан хорих болон зөрчлийн асуудлыг шийдвэрлэх, мөн ял шийтгэл эдэлж байгаа хүмүүсийн эрхийн асуудал хязгаарлагдсан, эрүү шүүлттэй холбоотой гэх мэтийн асуудлаар бол хариуцан ажилладаг. Тэгээд энэ шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн асуудлыг бол Энхболд гишүүн хариуцан бичсэн. Одоогоор бол хөдөө орон нутагт томилолтоор явсан учраас өнөөдөр би та бүхэнд энэ танилцуулах үүргийг бол хүлээж байна.

Энэ бүлэгт бол эрүү шүүлтээс ангид байх эрх, Эрүү шүүлтийн, эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тайлагнах асуудал, мөн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харилцааны нөхцөл байдлыг энэ бүлэгтээ тодорхой оруулсан. Мөн хорих анги, цагдан хорих байран дахь хүнлэг бус харьцааны талаар оруулсан байгаа. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь юунд байна вэ гэдгийг бас мөн тодруулж гаргаж ирсэн. Цэргийн анги байгуулагдах дүрмийн бус харилцаа бол бас хүний эрхийн байдлыг муутгахад тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулж байна гэж ингэж үзсэн.

Мэдүүлэг авах үеийн хүний эрхийн асуудал. Ингээд үндсэндээ өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрх хүртэл шударгаар шүүлгэх эрхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж ингэж үзсэн байгаа. Ингээд энэ бүлэгт бол үндсэндээ бүлэг тус бүрээр нь бичсэн мөн Хүний эрхийн Үндэсний комисст ирсэн гомдлууд, мөн тодорхой хэмжээний хийсэн судалгаанууд энэ бүхэн дээрээ тулгуурлаад ерөөсөө бичсэн бүлэг болгон дээрээ тодорхой хэмжээний 5-6 саналтай ийм бүлэг байгаа. Эрүү шүүлтээс ангид байх эрх үндсэндээ 6 саналыг оруулсан. Үүнд мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах явдал бол чухал байна гэсэн ийм саналыг оруулсан.

Мөн 1 мөрдөгч, прокурорт оногдох хэргийн тоог тэнцвэртэй боломжит хэлбэрээр мөрдөж шалгах, хяналт тавих, энэ боломжийг олгосон ачааллыг тэнцүүлэх асуудал чухал байна гэсэн энэ саналыг оруулсан. Мөн зориулалтын бус өрөөнд мэдүүлэг авч, зарим тохиолдолд эрүүдэн шүүсэн, зарим тохиолдолд өмгөөлөгчгүйгээр мэдүүлэг авч байгаа явдал нь хүний эрхийн байдлыг дордуулж байна гэсэн ийм дүгнэлт хийсэн. Уулзалт мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага хүний эрхийн зарчимд нийцүүлсэн, шинэчилсэн байдлаар зохион байгуулах хэрэгтэй байна. Тэнд байгаа камер тэнд оролцвол зохих ёстой оролцогчдыг бүрнээр нь бодитоор оролцуулах асуудал бол чухал байна гэж үзсэн.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээ хэрцгий хүнлэг бусаар буюу Хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын илтгэлийг, конвенцын хэрэгжилтийг тайлан бэлтгэх жишиг аргачлалтай болмоор байна. Тэгвэл илүү яг ямар асуудлыг эрүү шүүлт гэх юм, ямар асуудлыг хүнлэг бус харьц гэх юм гэдгийг нарийн тодорхой зааж өгч түүнийхээ дагуу илтгэлээ бэлтгэж явуулах явдал чухал байна. Ийм үндсэн 6 саналыг оруулсан.

Сэтгэцийн шинжилгээ ба хүний эрх гэсэн ийм бүлэг байгаа. Энэ дээр бол үндсэндээ эрүүгийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх явдал нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн шүүх заавал шийдвэрлэдэг баймаар байна. Зөвхөн мөрдөгчийн саналаар шийддэг биш. Энэ бол олон чухал ярвигтай байдлуудыг бас бий болгодог. Сэтгэцийн хувьд өөрчлөлттэй болсон хүмүүс өөрсдийнхөө дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх явдал их байна. Тэдгээр хүмүүсийг мөн тусад нь хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах нөхцөл байдал одоогоор тун төвөгтэй, ярвигтай байна гэсэн ийм саналыг оруулсан.

Хэрэг хариуцах хязгаарлагдмал завсрын гэж хэлж болохуйц чадвартай хүнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж, энэ төрлийн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна гэсэн ийм саналыг оруулсан.

Төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээлэл хамгаалах явдал бол бас манайд өнөөдөр ярвигтай байдал бий болсон байна. Тийм учраас мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журмыг аль болох ямар нэгэн дүрэм журмаар биш хуулиар зохицуулах явдал бол туйлын чухал байна. Хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг прокурорын саналаар шүүхийн зөвшөөрлөөр явуулах асуудал бол чухал байна гэдгийг оруулсан.

Мөн гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатад ил болгож, хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Яагаад гэвэл тэр нууц материалыг шүүгчээс өөр хэн ч мэдэлгүйгээр асуудлыг шийдвэрлэнэ гэдэг явдал бол гэм буруутай эсэхийг нь үнэн, зөв бодитой нотолж шийтгэл оногдуулж өгч байгаа эсэхэд эргэлзээ төрж байна гэсэн энэ гол агуулгыг оруулсан.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийг боловсронгуй болгох. Ялангуяа хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа эхлээгүй байгаа энэ гэмт хэргийн гомдол, мэдээллийн шинжтэй үйлдлийг шалгах шатад прокурорын хяналтыг сайжруулах, чанартай болгох, нэмэгдүүлэх явдал чухал байна гэж ингэж үзсэн.

Таслан сэргийлэх арга хэмжээний хувьд бол ялт ч үгүй цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хамгийн хүнд хэлбэртэй таслан сэргийлэх арга хэмжээг бол аль болохоор хэр хэрэглэхгүй байх олон улсын хүний эрхийн зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог байхыг бас анхааруулсан. Шүүгчийн хуульд заасан шийдвэрээр цагдан хорих, баривчлах шийтгэлийг хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, суллах ажиллагаанд мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах технологийн дэд бүтцийг шийдвэрлэх явдал бол манайд тулгамдаж байна гэдгийг оруулсан.

Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ асран хамгаалагч, харгалзан дэмжигч, мөн харгалзан дэмжигчгүй хүмүүс бага насны хүүхэд байгаа эсэхийг нягтлан шалгах, тэднийг цаашид нь хэн асран хамгаалах юм бэ? Төр хамгаалах уу? Хэрвээ үнэхээр тэр хүний аав ээж, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тодорхойгүй бол энэ асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдгийг шүүхийн шийдэх тогтоолд тодорхой бүлэг болгон зааж өгөхгүй бол насанд хүрээгүй хүүхдүүд нь хэний асрамжид үлдэж байгаа нь тодорхойгүй. Төр тэр хүн нь тэр хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах асуудал дээр хангалттай ажиллагаа явуулахгүй байгаа нь төвөгтэй байдал болгож байна гэж оруулсан.

Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн санал гаргасан албан тушаалтан уг арга хэмжээг цуцалсан бол хил хамгаалах байгууллагад нэн даруй мэдэгдэж байх шаардлагатай байна. Гэтэл олон жилийн өмнө хэрэгт холбогдоод өөрийнхөө гадагшийгаа гарах эрхийгээ цуцлуулчихсан байгаа, эрхээ хязгаарлуулчихсан байгаа иргэд онгоц буудал дээр бүх билет ийм тийм юмаа бичээд гадагшаа явах гээд очиход нь таны энэ гадагшаа явах эрхийг цуцлаагүй байна гэдэг үндэслэлээр эдийн засгийн болон сэтгэл санааны хямралд оруулж байгаа нөхцөл байдал бол бас их байна. Тийм учраас энэ асуудлыг бол шалгах, нэг мөр болгож шийдвэрлэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, үндсэндээ энэ ингээд 3 дахь бүлэг рүүгээ орж байгаа. Хорих анги, цагдан хорих байрны нөхцөлийг байнга сайжруулна гэсэн ийм саналыг оруулсан. Зөрчлийн хэрэгт давж заалдах эрхийг бол тун хурдан богино хугацаанд шийддэг байх шаардлагатай байна гэсэн. Мөн хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал чухал байна. Хохирлын бодитоор гэмт хэргийн хохирогч болоод хохирол нь төлөгдөлгүйгээр гэм хорын хохиролтой, мөн дээрээс нь сэтгэл санааны хохирлоо барагдуулж чадахгүй байгаа өчнөөн хүмүүс байна.

Тийм учраас энэ хохирол, хохирогч судлалын асуудлыг идэвхжүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх, мөн хохирсон иргэдийг эргэж нийгэмшүүлэх хэвийн амьдралд нь оруулах энэ асуудлыг зохистойгоор бүрэн шийдвэрлэх асуудал чухал байна. Эдгээр ажлуудыг хийхийн тулд мөн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг бол байнга хууль хяналтын байгууллагын ажилтнуудыг хүний эрхийн байдлыг нь сайжруулах дэмжлэг бүхий сургалт нөлөөллийн ажлуудыг хийх шаардлагатай байна гэж ингэж үзсэн. Ингээд би товч байдлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос шийдвэр гаргуулахаар өгч буй үндсэндээ 14, 21, 30 ингээд явцын дунд хэрэгжүүлэх 29 санал бол байна. Зайлшгүй Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулах 11 санал байна гэж ингэж гаргасан байгаа. Баярлалаа.

Б.Баярбаатар: Танд баярлалаа. Дараагийн танилцуулгыг Жаргалсайханы Хунан гишүүн танилцуулчих. 5 номерын микрофон.

Ж.Хунан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Тэгээд Хүний эрхийн Үндэсний комисс хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Энэ хүрээндээ 24 дэх илтгэлдээ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн асуудлыг бол онцгойлон, тухайлан тусгаж Улсын Их Хуралд танилцуулсан байгаа.

Сүүлийн 5 жилийн статистик харж үзэх юм бол энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа хүүхдийн тоо эрс нэмэгдэж байгаа. Ерөөсөө тогтмол нэмэгдэж байгаа ийм үзүүлэлт байгаад байгаа юм. Энэ дээр бид нар онцгой анхаарал хандуулахгүй бол болохгүй байна хүүхдүүд хохирсоор байна. Дээрээс нь

энэ хэрэг хянан шийдэх ажиллагаа өөрөө хүүхдийг давхар хохирох ийм нөхцөлийг бүрдүүлж байна гэдэг ийм дүгнэлтийг бол хийсэн.

Та бүхэнд сүүлийн 5 жилийн зарим статистикийг танилцуулъя. Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг зарим гэмт хэргийн тоон мэдээллийг харах юм бол энэ бага насны хүүхэд буюу 14-өөс доош насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа тоо бол энэ аюулын харангыг бол бид нарт бол харуулж байна. Өөрөөр хэлбэл энэ асуудал дээр бид нар онцгойлон анхаарал хандуулж, дүгнэлт хийж, арга хэмжээ авахгүй бол энэ бүр бүр болохоо байж байна гэдэг ийм.

Сүүлийн 5 жилд бол 990 хүүхэд 14-өөс доош насныхан би энэ зарим нөгөө тоог нь дурдаж байгаа. Хүүхэд бол бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон. Энэ бол цагдаагийн байгууллагаас өгсөн мэдээллээр гэсэн үг. Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй бас тохиолдлууд байхыг бол үгүйсгэхгүй гэж харж байгаа.

Прокуророос хэрэгсэхгүй болгосон болон прокуророос яллах дүгнэлт үйлдсэн хэргийн тоог харах юм бол энэ 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн тоог ярьж байгаа энэ дээр бол өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 859 хэрэгт бол яллах дүгнэлт үйлдсэн. Хэрэгсэхгүй болгосон 63 ийм кэйс байгаад байгаа юм.

Энэ насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлтийг харах юм бол 14 насанд хүрээгүй хүнийг хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг бол илрүүлэлт нь 42.3 хувьтай байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол 50 хувьдаа ч хүрдэггүй ийм нөхцөл байдал байна гэсэн үг.

Харин энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын шүүх эмнэлэгт үзлэгт хамрагдсан хүүхдүүдийг бид нар харах юм бол энэ тоо бүр эрс өндөр байгаа. Одоо бүртгэгдсэн хэргээсээ бол өндөр. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бол нийтдээ 4161 насанд хүрээгүй хүн бол хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон үндэслэлээр үзлэгт хамрагдсан байгаад байгаа. Үүнээс 14-өөс доош насныхан нь харах юм бол 1745-н 14 насанд хүрээгүй хүрээгүй хүүхэд үзлэгт хамрагдсан. Тэгээд гэмт хэргийн гаралт, яллах дүгнэлт үйлдсэн энэ дүнтэй харьцуулах юм бол энэ 2, 3 дахин өндөр байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол бид нар бас дүгнэлт хийх ёстой. Яагаад энэ тоо ингэж багасаж байна, яагаад энэ үзлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо ийм өндөр байгаа гэдгийг. Дээрээс нь 14 насанд хүрээгүй төрсөн болон үр хөндүүлсэн хүүхдийн тоог сүүлийн 5 жилээр үзэх юм бол төрсөн 98 хүүхэд байгаа 14 насанд хүрээгүй, 10-а14 насны. Үр хөндүүлсэн 215 хүүхэд байгаа. Тэгэхээр энэ бол маш өндөр тоо. Тэгээд энэ цаанаа гэмт хэргийг бол агуулж байна. Өөрөөр хэлбэл, энэний цаана гэмт хэрэг бол байна гэдэг ийм зүйлийг хэлж болохоор байгаа.

Үндсэндээ бол Хүний эрхийн Үндэсний комиссоос ямар дүгнэлтийг хийж байгаа вэ гэхлээр насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, нэн ялангуяа бага насны хүүхдийг хүүхдийн хүчингийн гэмт хэргийн гаралт буурахгүй тогтмол өсөж байна. Тийм учраас насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй болгох, өөрчлөх, шинэчлэх ийм шаардлага байна.

Дээрээс нь бага насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа энэ шалтгаан, нөхцөлүүдэд дунд энэ пидофил буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж таашаал авдаг ийм гаж зуршилтай хүмүүсийг илрүүлдэг, оношилдог, эмчилдэг, хяналт тавьдаг ийм механизм тогтолцоо байхгүй байгаа учраас бид нар бас эдгээр хүмүүс хэрэг давтан үйлдэх ийм нөхцөл боломжийг бол нэмэгдүүлж байна. Тийм учраас энэ пидофилийн судалгааг дэлгэрэнгүй хийх, энэ дээр бид нарт холбогдох зохицуулалтыг бий болгох ийм шаардлага байна гэж дүгнэсэн.

Дээрээс нь энэ насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн судалж байгаа судалгаанууд маань үндсэндээ бол тухайн байгууллагын хэмжээнд ашиглагддаг, өөрөөр хэлбэл хязгаарлагдмал хүрээнд энэ нь ашиглагдаж байгаа учраас энэ тэмцэх урьдчилан сэргийлэх ажил бас үр дүнгүй байгаад байна. Дээрээс нь хийгдэж байгаа судалгаанууд нь ерөнхийдөө бол яг хэв загварын тэгээд л хязгаарлагдмал мэдээллийг бол гаргаж ирж байна. Тийм учраас энэ насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн бүүр нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг хийх шаардлага байна. Өөрөөр хэлбэл, криминологийн судалгааг хийе. Ингэхдээ зөвхөн байгууллагын түвшинд биш, холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулаад, оролцуулсан өргөтгөсөн ийм ажлын хэсэг гаргаж энэ дээр маш нарийн дэлгэрэнгүй судалгааг хийх ийм хэрэгцээ шаардлага байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн.

Дараагийн нэг асуудал бол энэ бага насны хүүхдүүдийн хүчингийн гэмт хэргийн хохирогч болж байгаа явдал магадгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маань өөрөө хүүхдэд ээлтэй биш байгаа учраас хүүхдүүд энэ хуулийн байгууллагад хандахгүй байгаад байна, энэ шүүхийн байгууллагад хандахгүй байгаад байна гэж харж байгаа.тийм. Энэ үүднээс бол Хүний эрхийн Үндэсний комисс бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг шийдвэр хэлсэн 40 хавтаст хэрэгт бол дүн шинжилгээ хийсэн. Тэгээд энэ дүн шинжилгээ хийсэн хавтаст хэргээс бол үндсэндээ энэ хэрэг хянан шийдэх ажиллагаа хүүхдэд ээлгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн байгаа. Энэ ямар үзүүлэлтээр бас харагдаж байгаа юм бэ гэхлээр хамгийн эхний ээлжид бага насны хүүхдэд хууль сануулж гарын үсгийн баталгаа авдаг. Энэ практик маань бол хүүхдэд давхар шаардлагагүй дарамтыг бий болгодог, айдсыг бий болгодог, сэтгэл зүйг нь бол дахин гэмтээдэг ийм практик байна.

Дүн шинжилгээ хийсэн 40 хавтаст хэргээс 21 хэрэгт нь мөрдөгч мэдүүлгийн тэмдэглэл болон эрүүгийн хэрэг хянан шийдэх ажиллагаанд саад учруулсан, худал мэдүүлэг өгсөн бол хариуцлага тооцох талаар сануулсан байгаад байгаа юм. Мөн баталгааны хуудаст гарын үсэг зуруулсан байгаад байгаа юм. Уг нь бол бага насны хүүхдийг, бага насны хүүхдэд хууль сануулах ийм баталгаа авахыг бол хориглосон байдаг. Харамсалтай нь өнөөдөр практикт бол энэ нь бол үргэлжилдэг, энэ нь бол хийгдсээр байна гэдэг ийм дүн гарч байна.

Үүнээс гадна энэ мэдүүлэг авч байгаа мөрдөгчийн хүйсийг бол бид нар бас үзсэн байгаа. Тэгээд үндсэндээ бол 40 хавтаст хэрэгт нийт 112 мэдүүлэг бол авагдсан байна. Үүнээс 81 буюу 72.3 хувьд нь бол эрэгтэй мөрдөгч авсан байгаад байгаа юм. Тэгэхээр хохирогчийн тоог харах юм бол дийлэнхдээ бол эмэгтэй хүүхэд хохирогч байдаг. Тэгээд энэ тохиолдолд эрэгтэй мөрдөгч мэдүүлэг авч байгаа болсон явдлын талаар асууж, сонсож байгаа нь бол нөгөө хүүхдэд айдсыг бий болгоно, эвгүй байдлыг бий болгоно, дээрээс нь давхар дарамтыг үүсгэдэг гэж үзсэн.

Хэрэг хянан шийдэх тухай хуулиар бол насанд хүрээгүй хүнээс бол мэдүүлэг авахдаа дээд тал нь 2 цагийн хугацаанд бол тасралтгүй мэдүүлэг авах ийм зохицуулалт үйлчилж байгаа. 2 цагаас дээш авах тохиолдолд 30 минутын завсарлага авахаар бол хуулийн зохицуулалт байгаа. Гэсэн хэдий ч 40 хэргээс бол 4 хэрэгт нь бол 2 цагаас дээшээгээ завсарлага авахгүйгээр мэдүүлэг үргэлжлүүлэн авсан ийм тохиолдол гарсан. Мөн энэ мэдүүлэг авах хугацаа маань бас хэт урт байгаа нь бол энэ хүүхдэд маш том дарамт тээр болдог. Үндсэндээ бол хүүхдэд хүнлэг бус харьцаж байгаа, хүүхдийг эрүүдэн шүүж байгаагаас бол бас ялгаагүй ийм нөхцөл байдлыг бий болгож байгаа.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдүүлгийн давтамжийн асуудал бол бас хөндөгдсөн. Давтамжийг бол бид нар харсан байгаа. Энэ дээр бол үндсэндээ бол нийтлэг мэдүүлэг авсан тоо бол 2 байгаа. 2 болон 3 байгаа. Дээд тал нь 6 удаа мэдүүлэг авсан тохиолдол байна. 6 удаа мэдүүлэг авсан 2 тохиолдол байгаа. Тэгэхээр үндсэндээ бол энэ болсон явдлын талаар тэр хүүхдээс байн байн, дахин дахин давтан тэр болсон явдлыг асуух нь бол хүүхдэд сэтгэл зүйг нь бол дахин дахин гэмтээх ийм эрсдэлийг дагуулж байна. Тийм учраас энэ практик бол бас буруу юм.

Тийм учраас энэ мэдүүлэг авах энэ ажиллагааг, энэ давтамжийг бол өөрчлөх, мөн олон улсын хүний эрхийн байгууллагуудаас өгдөг зөвлөмжид бол нийцүүлэх ийм бас шаардлага байна гэж харж байгаа юм.

Анхаарал татсан дараагийн асуудал бол энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдээс асууж байгаа асуултууд маань өөрөө бол нөгөө хүүхдийн хөгжил насны онцлогт нийцээгүй ийм асуултууд асууж байна. Тэгэхээр энийг бол бид нар эрс өөрчлөх шаардлагатай. Энийг бол шинэчлэх ийм шаардлага байна. Мөрдөгч.../минут дуусав./

Б.Баярбаатар: Микрофоныг нь сунгаад өгчхөөрэй.

Ж.Хунан: Мөрдөгч солигдож байгаа тохиолдол мөн нийтлэг байна. Нийт 40 хэргээс 7 хэрэгт нь бол мөрдөгч солигдоогүй, 33 хэрэгт нь бол мөрдөгч бол 2-оос дээш удаа солигдсон. Хамгийн их солигдсон буюу нийтлэг байгаа нь 3 буюу түүнээс дээш удаа солигдсон. 16 хэрэгт бол мөрдөгч 3 удаа солигдсон доод тал нь. Тэгэхээр бол энэ болгонд нөгөө мөрдөгч хүүхэдтэй ярилцан хүүхдээс мэдүүлэг авдаг ийм практик бол байгаад байна. Тийм учраас энийг бол бид нар нөгөө хүүхдэд ээлгүй, хүүхдийг бас эрүүдэн шүүж байгаагаас ялгаагүй гэж үзэхээр байгаа.

Мэдүүлэг авах орчин бол хүүхдэд ээлтэй байх ёстой, хүүхдэд аливаа айдсыг төрүүлэхгүй, хүүхдэд тайван орчинд бол болсон явдлын талаар ярих нь бол хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцнэ. Гэсэн хэдий ч өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийт ашиглагдаж байгаа 565 мэдүүлэг авах өрөөнөөс 49 өрөө нь бол насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөгөөр, зориулалтаар бол тохижуулагдсан гэж үзэж байгаа боловч яг бодит байдал дээрээ бол хэдэн хүүхдийн тоглоом байршуулсан, мөн зөөлөн буйдан байршуулснаас өөр хүүхдэд ээлтэй, хүүхдэд айдас төрүүлэхгүй ийм орчин бол бас байхгүй байна гэдгийг хэлж байгаа юм.

Үндсэндээ эдгээр нөхцөл байдлаас бол бид нар ямар дүгнэлтийг хийж байна вэ гэхлээр энэ мэдүүлэг авах ажиллагаа бол хүүхдэд ээлтэй биш байна. Энийг бол бид нар шинэчлэх, өөрчлөх, хүүхдэд ээлтэй болгох зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөн нэг чухал асуудал байгаа. Энэ нь юу вэ гэхлээр хүүхдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал. Хүүхдийн хууль зүйн туслалцаа авах эрх хуулиар бол баталгаажуулсан хэдий ч 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хууль ёсны төлөөлөгч буюу бусад оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд өмгөөлөгчөөр хангах ийм зохицуулалт үйлчилж эхэлснээс хойш бол хууль ёсны төлөөлөгч ихэвчлэн ураг төрлийн хүчингийн хувьд бол эцэг эх нь бол өмгөөлөгч авахаас татгалздаг, өмгөөлөгч авахгүй байх тохиолдол бол нийтлэг болсон.

40 хавтаст хэргээс 19 хэрэгт л хүүхдүүд өмгөөлөгчтэй оролцсон байгаа. 21 хэрэгт нь бол өмгөөлөгч аваагүй. Өмгөөлөгч аваагүй нь бол эргээд нөгөө хүүхэд процессын явцад өөрийн эрхээ эдлэх, мөн хохирол болон бусад асуудлаа, бусад эрхээ бол хангуулах энэ боломж нь бол хязгаарлагдаж байгаа гэж үзэж байгаа. Тийм учраас энэ өмгөөлөгч авах эрхийг бол сэргээх шаардлагатай. Яагаад сэргээх гэж байгаа юм гэхлээр 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бол насанд хүрээгүй хохирогч заавал өмгөөлөгчтэй орох зохицуулалт байсан. Өөрөөр хэлбэл хууль ёсны төлөөлөгч, эцэг эх нь хүсэлт гаргасан, гаргаагүйгээс үл хамаараад заавал өмгөөлөгчтэй оролцдог байсан бол энэ маань 2017 оноос хойш өөрчлөгдсөнөөр энэ хүүхдүүд дахин хохирох ийм бас нөхцөл, боломжийг бол бүрдүүлсэн байна гэж харж байгаа.

Энэ бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийн энэ хохирлоо барагдуулах эрх бол хангагдахгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн. Дүн шинжилгээ хийсэн. 40 хавтаст хэргээс энэ хохирол нэхэмжилсэн тохиолдол бол маш бас хангалтгүй гэж дүгнэсэн байгаа. 40 хэргээс 17 хэрэгт нь л хохирол нэхэмжилсэн. Тэгээд ихэвчлэн хохирол нэхэмжлээгүй тохиолдол нь өмгөөлөгчгүй оролцсон тохиолдолд.

17 тохиолдлоос 10 хэрэгт нь бол хууль ёсны төлөөлөгч хохирлыг нэхэмжилсэн байгаа. Өөрөөр хэлбэл эцэг эх юм уу, ах дүү хамаатан садан нь. 7 хэрэгт нь бол өмгөөлөгч нь нэхэмжилсэн байгаад байгаа. Тэгээд эндээс бол бид нар ямар дүгнэлтийг хийж байгаа вэ гэхээр энэ хохирол нэхэмжлэх асуудал бол хангалтгүй байна. Хүүхдийн хохирол барагддаггүй байна. Энэ дээр бие махбодын хохирол болон сэтгэл санааны хохирол шийдвэрлэлт бол үндсэндээ бол хийгддэггүй гэдэг ийм дүгнэлтийг бол хийж байгаа.

17 хэргээс бол нийт хохиролд нэхэмжилсэн үнийн дүнг харах юм бол хохиролд гаргуулсан үнийн дүнг харах юм бол бас чамламаар дүн байгаа. Энэ нь бол 50 сая 30939 төгрөгийг бол хохиролд гаргуулсан л ийм үзүүлэлт байна. Мөн дээрээс нь энэ хүүхдийн нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг бол ерөөсөө нэхэмжилдэггүй, энийг нь бол шийддэггүй ийм практик бол үргэлжилсээр байна.

Хохирлоос гадна энэ хүүхэд хамгааллын бусад бүтцийн оролцоо үндсэндээ бол хангалтгүй байна гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл энэ хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ёстой, хүүхдийг хамгаалах ёстой, хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газраас

томилогдож байгаа хууль ёсны төлөөлөгчөөр томилогдож байгаа хүүхдийн мэргэжилтэн, мөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэсэн энэ бүтцийн үйл ажиллагаа бол хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн. Энэ дээрээс 40 хавтаст хэрэгт бол бид нар хяналт шалгалт хийхэд 6-хан хэрэгт нь бол нөхцөл байдлын үнэлгээг бол өөрөөр хэлбэл хамтарсан баг нөхцөл байдлын үнэлгээг хийсэн. 34 хэрэгт нь бол ерөөсөө хийгээгүй, хийгдээгүй ийм байдалтай.

Аюулын зэргийн үнэлгээг 7 хэрэгт нь бол хийсэн байсан. Өөрөөр хэлбэл 7 хэргийн хохирогч хүүхдэд бол хийсэн. 33 хэрэгт нь бол ерөөсөө хийгээгүй байсан. Ийм үзүүлэлт байгаа. Үүнээс гадна Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны оролцоо бол ерөөсөө ямар ч кэйст энэ 40 хэрэг дээр алинд нь ч байгаагүй. Уг нь бол Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо бол гэмт хэргийн хохирогч, холбогдогч, гэрч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ийм хүүхэд хамгааллын чухал бүтэц байгаад байдаг. Тэгэхээр энэ бол хүүхэд хохирох, мөн хүүхэд зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэхээс гадна бол хэрэг нь хэрэг нь шийдвэрлэгдсэний ард бол бас бусад үйлчилгээгээ авахад бол энэ хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийж байгаа.

Дээрээс нь энэ хүүхэд хамгааллын энэ бусад бүтцийн ер нь бол чадавх мэргэшсэн байдал бол хангалтгүй гэдэг ийм дүгнэлтийг бол хийсэн байгаа. Тэгээд үндсэндээ эдгээр нөхцөл байдлыг үндэслээд Хүний эрхийн Үндэсний комиссоос 9 санал, зөвлөмжийг бол Улсын Их Хуралд хүргүүлсэн. Энэ хүрээндээ хамгийн нэгд нь бол насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан хийх, судалгааны үр дүнг үндэслэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэлбэрээ шинэчлэх гэдэг ийм санал, зөвлөмжийг гаргасан.

Хоёрт нь бол бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж таашаал авдаг бэлгийн гаж зан үйлийн эмгэгтэй гэмт хэрэгт яасан? Тэгвэл больчих уу. Харин тийм уг нь өгчихсөн байгаа. Тараагдчихсан байгаа. Тэгвэл ингээд зогсоочих уу?

Б.Баярбаатар: Тэгье. Хунан гишүүнд баярлалаа. Танилцуулгаа бараг 40, 50 минут хийчих шиг боллоо. Одоо гишүүд асуулт асууна. Нэлээн бас сэтгэл эмзэглүүлсэн мэдээллийг хийлээ. Ер нь хангалтгүй гэхэд ч багадаа л. Хангалтгүйгийн хангалтгүй гэж байдаг тэр хэмжээнд оччихоор хэмжээний л асуудал яригдлаа л даа сая. Гишүүд асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Энхтуяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Хүний эрхийн 24 дүгээр илтгэл бид хэд яах вэ бас чуулган дээр ч сонссон. Одоо энэ гарч байгаа зөвлөмжийг өшөө сайн яаж сайжруулах вэ гэдэг дээр л Байнгын хороод дээр дахиж сонсож байгаа. Ер нь их зөөлөн л саналуудыг өгсөн байгаад байгаа юм. Миний бодлоор бол яг энэ бэлгийн хүчирхийлэл үйлдэж байгаа, бага нас, нэн ялангуяа бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, тэдэнд хяналт тавих гэхээсээ илүүтэй хариуцлагын тогтолцоог нь чангалчихмаар байгаа байхгүй юу. Би бас нөгөө тариа тарьдаг байя гээд л бас нэлээд тэгж хэлсэн. Сошиал дээр ч гэсэн энэ маань нэлээд явагдсан. Энэ нь ямар тариа вэ гэхлээр дур хүслийг нь бууруулдаг. Бэлгийн юу гэдэг юм нөгөө бэлэг эрхтнийг нь ажиллагаагүй болгодог гэдэг юм уу, тэр дур хүслийг нь дарангуйлдаг л тийм тариа.

Тэгээд олон улсад яг энийг хэрэглэдэг. Яг сошиал дээр бол хүмүүс цаазаар авах хэрэгтэй л гэдэг юм. Тэгээд Монгол Улс цаазаар авахгүй ч гэсэн тухайн хүмүүст бас хиртэсхийм бас хариуцлага хүлээлгээд байвал уг нь их зүгээр.

0-6 насны 5 жилийн хугацаанд 350 хүүхэд, жилд 60-80 хүүхэд 0-6 насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч гэсэн үндэслэлээр шинжилгээнд хамрагдаж байна. 14 орчим, 14, 13, 12 настай хүүхдүүдийг бол та хэд эндээ бас нэг талын бичсэн байгаа асуудал нь бэлгийн бойжилт эрт явагдаж байгаа холбоотой хүүхдүүд хоорондоо үерхээд бэлгийн харьцаанд орох асуудал бас байна гэдгийг хэлж байгаа юм. Энэ уг энэ бол бас ингээд хүүхдүүдийг хараад байхад хоорондоо 13-тай, 14-тэй, 12 настай хүртэл хүүхдүүдийн гаднаас харахад 12 настай хүүхэд гэж харагдахааргүй хүртэл эрт бойжилт нь явж байгаа хүүхдүүд ч гэсэн байгаа шүү дээ. Тэгэхээр эдгээр хүүхдүүд хоорондоо үерхээд бэлгийн харьцаанд орж байгаа бол эрэгтэй хүүхдийн шууд хорьж байгаа асуудал нь бол өөрөө тухайн эрэгтэй хүүхдийн эрхийг бас ноцтой зөрчиж байгаа асуудал мөн учраас ядаж энэ агуулгаар нь уг нь бол бас хардаг байх өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Тэгэхээр энэ сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож байгаа 17 хүүхэд бол магадгүй хоорондоо үерхээд ийм асуудалд орсон хүүхдүүд байхыг үгүйсгэхгүй.

Тэгэхээр энийг бас нөгөө талдаа эсрэг талаар нь ингэж харахгүй л болохгүй. Хүүхдүүдийн асуудлыг хоорондын асуудал нь. Гэтэл яг тухайн насанд хүрсэн хүн бүр 0-6 насны хүүхдийг хүчирхийлж байгаа асуудлыг бид нар зүгээр яриад өнгөрөх нь үнэхээрийн маш буруу байгаад байгаа юм. Тэгээд хамгийн гол нь энэ ойр тойрны хүрээндээ, хамаатан садны хүрээнд танилын хүрээнд үйлдэгдэж байгаа учраас нэрээ хичээгээд эцэг эх нь энэ асуудлыг нуун дарагдуулах явдал байна. Яах.../минут дуусав./

Б.Баярбаатар: Хунан гишүүн хариулчих.

Ж.Хунан: Тэгэхээр Ариунзаяа гишүүнтэй санал нэг байгаа. Бид нар арга хэмжээ авах ёстой. Ялангуяа 3 асуудлыг хөндлөө. Нэг нь бол энэ химийн аргаар тайган болгох ийм практик. Олон улсад энэ аргыг бол хэрэглэдэг. Бэлгийн даавар буюу бэлгийн дур хүслийг үүсгэдэг тестостероны хэмжээг багасгадаг ийм тарилга бол ашигладаг. Азид бол Өмнөд Солонгос Улс 2011 оноос хойш энэ аргыг хэрэглэж байгаа. АНУ-д 1996 оноос бол нэвтрүүлээд хэрэглэдэг ийм практик байгаа. Энэ чиглэлээр бол хийгдсэн судалгаа бол одоогоор байхгүй.

Тэгэхээр бидний энэ санал болгоод байгаа энэ ажилд бол энэ бүр нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг бид нар ер нь хийх ёстой. Тэгэхээр ямар ч л байсан бид нар энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой энэ салбар бүхнээс хүмүүсийг төлөөллийг оролцуулаад энийг бид нар бүхэлд нь цогцоор нь авч үзэж судалж маш нарийн судлах ийм шаардлага байгаад байгаа юм. Тэгэхээр энэ санал дотор бол яг энэ тарилгатай холбоотой өөрөөр хэлбэл химийн аргаар зандан болгох энэ ажлыг бол бид нар судлаад бас гаргаж ирэх ийм боломжтой байгаад байгаа юм. Тэгээд энийг бас хийх нь зөв гэж харж байгаа юм.

Бага насны хүүхдүүд 0-6 насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр үзлэгт хамрагдаж үнэхээр харамсмаар байгаад байна. Энийг бид нар шалтгаан, нөхцөлийг нь мөн ялгаа байхгүй бүүр нарийвчилж судлах бас хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм. Үндсэндээ бол бидний харж байгаагаар Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын шүүх эмнэлэгт үзлэгт хамрагдаж байгаа

хүүхэд бүрийн цаана гэмт хэрэг байх боломжтой гэж харж байна. Зөвхөн бүртгэж байгаа нь л тийм юм бага байгаа учраас.

Хүүхдүүд хоорондоо үерхээд гэмт хэрэгтэн болж байгаа явдал бол бас анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгаад байна. Энэ нь бол Эрүүгийн хуулийн зүйл, ангийг бид нар энэ энэ зүйл, ангийн шинжийг бид нар дахин тодорхойлох хэрэгцээ шаардлага байгаад байна. Өөрөөр хэлбэл, өнөөдөр 14 наснаас доошоогоо хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон бол хэнбугай нь ч автоматаар гэмт хэрэгтэн болж байгаа асуудал. Бэлгийн бойжилт эрт эхэлж байна. Хүний эрхийн Үндэсний комисс болон энэ холбогдох байгууллагуудын хийсэн судалгаагаар бол 12 наснаас үндсэндээ бол энэ бэлгийн харилцаа гэж юу болохыг хүүхдүүд мэддэг болчихсон байна. Физиологийн хувьд ч гэсэндээ өсгөлөн болчихсон байна. Өөрөөр хэлбэл 12 настай ч гэсэндээ нас биед бас хүрсэн өндөртэй бие бялдрын хувьд бол ийм гадна төрхийн хувьд бол ийм насанд хүрсэн хүнээс ялгагдахааргүй ийм хэмжээнд очсон байгаа юм.

Тэгэхээр энэ гэмт хэргийн шинжийг бид нар дахин тодорхойлж энийг бид нар Эрүүгийн хуульдаа өөрчлөлт оруулахгүй л бол энэ өөрчлөгдөхгүй. Энэ асуудлыг бол яг практик дээр ажилладаг өмгөөлөгч нар хамгийн ихээр ярьж, сэтгэл санаа нь зовниж байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын тэнд ажилладаг удирдах албан тушаалтнууд бас энийг ярьж байна. Хоорондоо үерхээд гэмт хэрэгтэн болж байгаа нэг нь. Тэгэхээр энэ бид нар энэ гэмт хэргийн зүйлчлэлийг мөн шинжийг бид нар дахин харж энэ дээр өөрчлөлт хийхгүй бол хүүхдүүд мөн зүгээр үерхээд хайр дурлалын үндсэн дээр бэлгийн харьцаанд ороод болсноороо гэмт хэрэгтэн болох ийм.../минут дуусав./

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Харин тийм. Энэ хүүхдүүдийн бас энэ бэлгийн бойжилт их эрт эхэлж байгаа. 9 настай хүүхэд охин хүүхэд сарын тэмдэг нь ирчхэж байгаа гэдэг ч юм уу нөгөө орчин цагийн хүүхэд бол өөрөө бас яг энэ бэлгийн бойжилт талаасаа бол их эрт эхэлж байгаа. Гэхдээ бас хүмүүс энийг битгий буруу ойлгочхоосой гэж би хүсээд байгаа юм.

Яагаад гэхлээр нөгөө Нямбаатар дарга энэ 14 нас гэдгийг л оруулж байхад хэчнээн маш их ийм маргаан үүссэн шүү дээ. Тэгэхээр нөгөө энэ агуулга талаас нь хүүхдүүд хоорондоо үерхэж байгаа бол яах вэ гэдгийг бас харахгүй бол энэ нөгөө талдаа бас эрэгтэй хүүхдүүд нь бас хохироод байна. Хүүхдүүд бас мэдэхгүйгээсээ болоод энэ юу гэдэг юм энэ харилцаанд орчхоод байна гэдэг асуудал.

Хоёр дахь нь энэ цахимтай холбоотойгоор энэ хар даа 2023 онд иргэн “А” фэйсбүүкийн хуурамч аккаунт үүсгээд өсвөр насны 84 охинтой танилцсан харилцаа тогтоогоод тухайн охидыг ятгах, сүрдүүлэх зэргээр зургийг нь аваад тэгээд олон нийтэд түгээнэ шүү гэж сүрдүүлээд бэлгийн харьцаанд орсон гэж байгаа байхгүй юу. Цахим харилцааг яах вэ?

Б.Баярбаатар: Хариулъя 5 номер.

Ж.Хунан: Хүний эрхийн Үндэсний комисс болон холбогдох байгууллагуудын судалгаагаар бол энэ цахим орчинд хүчирхийлэлд өртөх явдал түгээмэл байгаад байна. Бүүр 6 дугаар ангиасаа авхуулаад хүүхдүүд маань энэ цахим хүчирхийлэлд

өртөж байна. Зарим нь бүүр ноцтой хэлбэр буюу энэ цахим хүчирхийллийн улбаатайгаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа тохиолдлууд цөөнгүй байна. Энэ дээр бид нар нөгөө зохистой хэрэглэл бий болгох. Хүүхдүүдийн цахим орчин дахь энэ цахим орчныг ашиглах энийг бол бид нар бас шууд хатуу хязгаарлах нь бол боломжгүй зүйл. Тийм учраас бид нар энэ дээр бол зохистой хэрэглээг таниулах, сурталчлах, өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг чадвар суулгах мэдлэгжүүлэх ийм бол хэрэгцээ шаа.../минут дуусав./

Б.Баярбаатар: Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууна.

Д.Энхтуяа: Надад 3 тодруулах зүйл байна. Эхний сэтгүүлчдийн сэтгүүлчид бол хүний эрхийг хамгаалагч гэдэг дээр санал нэг байна. Тэгээд энэ тоо баримтаас харахад 2023 онд дэлхийн 109 орноос хэвлэл мэдээллийн эрх чөлөөгөөрөө манай улс 88 дугаарт байсан. 24 онд 180 орноос 109 дүгээр байранд ороод 1 жилийн хугацаанд 21 байр ухарсан. Үүнийхээ шалтгааныг хэвлэл мэдээллийн хууль зүйн орчин бол 21 байраар ухарсан байна. Хамгийн ноцтой нь сэтгүүлчдийн эрх чөлөөнд халдаж байгаа энэ үзүүлэлт бол 34 байраар ухарсан учраас 1 жилийн дотор энэ 21 байраар хэвлэл мэдээллийн эрх чөлөө ухарсан байна гэсэн ийм дүгнэлт, тайлан бол бид нар авсан.

Тэгэхээр энэ дээр юу харагдаж байна гэхээр яах вэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэлэлцэгдэнэ нэлээн олон зүйл заалтууд орсон нэлээн дэлгэрэнгүй ийм хуулийн төсөл орж ирсэн байгаа. Энэ дээр бол энэ салбарынхан болон энэ их хурал дээр бас өргөн хэлэлцүүлэг явна гэдэгт ойлгомжтой байна.

Хамгийн гол нь энэ сэтгүүлчдийн хүний эрх хамгаалагчдын энэ эрх нь өөрсдөө зөрчигдөөд байна. Энэ 34 байраар 1 жилийн хугацаанд ухарна гэдэг бол маш том ухралт гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Эрүүгийн хууль дээр яг Эрүүгийн хуулиар хүний нэр хүндэд халдсан гэдэг ийм зүйл, заалтаар яллагдсан хэвлэл мэдээллийн байгууллагынхан тийм их байдаггүй боловчиг ер нь залхаан цээрлүүлэх маягтай ер нь бол бүх л хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ цагдаа, шүүхийн хаалгыг бол сахиастай. Ер нь бол энэ хэвлэл нийтэлснийхээ төлөө цагдаад дуудагдах асуудал сүүлийн үед бол яг үнэндээ хавтгайрсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр бол мэдээжийн хэрэг энэ хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах ёстой. Хүний эрх талаасаа энэ хүний эрх хамгаалагчид маань өөрсдөө эрх нь зөрчигдөөд байна гэдэг дээр ямар яг бодитой санал санаачилгыг оруулж байгаа вэ? Тэр 6 санал санаачилгыг энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тусгуулж өгөх талаар бас та бүхнээс энэ 6 санал санал хайж санаачилгыг бол бас нэлээн манлайлж яваасай гэж бодож байна. Тэгэхээр энийг бол яг тодорхой оруулах хэрэгтэй байх гэж ингэж бодож байна. Энэ дээр та бүхний саналыг сонсьё.

Хоёрт нь 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль байгаа. Энэ 13 онд батлагдсан энэ хууль бол 2016 онд бол өөрчлөлт орсон. 16 оноос бол Гэрч, хохирогчийг хамгаалах хуульд ямар ч өөрчлөлт оруулаагүй байгаа. Тэгэхээр 16 онд орсон хууль өөрчлөлтөөр бол гэрч, хохирогчийг хамгаалах Тахарын алба гэж ингэж байгуулагдсан байгаа. Тэгээд энэ Тахарын албыг бол төсөв мөнгөний асуудлаас болоод татан буулгачихсан. Энэ Тахарын алба бол ерөнхийдөө энэ ардчилал хөгжсөн, хүний эрхийг дээдэлсэн бүх л оронд энэ гэрч, хохирогчийг хамгаалдаг ийм систем байдаг. Манайд энэ системийг нэвтрүүлэх гэж

үзээд тэгээд 10 харамсалтай нь төсөв мөнгөнөөсөө болсон гэсэн ганцхан л ийм шалтгаанаар бол татан буугдсан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр энэ сая та бүхний өгсөн энэ мэдээлэл дээр бол энэ гэрч болсныхоо төлөө, хохирогч болсныхоо төлөө, дээрээс нь энэ насанд хүрээгүй хүүхдүүд бол маш их хохирч байна.

Б.Баярбаатар: 1 минутаа авах уу? 1 минут сунгачихъя.

Д.Энхтуяа: Тэгэхээр энэ дээр энэ Тахарын албыг байгуулах тал дээр энэ тодорхой санаа, санаачилгыг манай Хүний эрхийн комиссоос гаргаач ээ гэсэн ийм хоёр дахь асуулт байна.

Гуравт нь ер нь бол энэ үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө дан ялангуяа энэ дээр бол залуучууд их хамрагдаж байна. Энэ гавтай, гав гинжтэй бас энэ ял авдаг энэ байдал бол гэрт байгаа нөгөө бага насны хүүхдэд бол сэтгэл зүйн хувьд маш том дарамт ордог юм байна. Тэгэхээр энийг бол энэ хөгжсөн орнуудад бол энийг хүүхдийн эрхийг зөрчиж байна гэсэн ийм зөрчил гэж үздэг юм байна л даа.

Гэтэл манайд сүүлийн үед даа ялангуяа үзэл бодлоо илэрхийлсэн бага насны хүүхэдтэй залуучууд гав гинжтэй 1 жил, 2 жил, 3 жил гээд энэ яах вэ байдаг юм байна л даа энэ хэсэг хугацаанд. Тэгэхээр энэ дээр нөгөө бага насны хүүхэд хохирч байгаа гэсэн ийм үзүүлэлт энэ дээр та бүхэн судалгаа шинжилгээ хийсэн болов уу? Ийм 3 асуудал.

Б.Баярбаатар: 4 номер.

С.Дондов: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Эхний удаад бол энэ манайх хэвлэлийн эрх чөлөөнийхөө юугаар эрс муу гэсэн энэ үнэлгээ авсан хэвлэлийн индексээрээ. Энэ яахын аргагүй олон чухал хүчин зүйлүүдээс шалтгаалж байгаа. Нэгдүгээрт зайлшгүй Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль 1998 оноос өнөөдрийг хүртэл хэрэгжихдээ хангалттай хэрэгжээгүй. Шинэ хуулийг бий болгож батлах санаачилгууд дутмаг байгаа гэдэг асуудал яахын аргагүй орж байгаа.

Хоёрдугаарт бол хэвлэл мэдээллийн чиглэлээр ажилладаг сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх, нийтийн мэдэх эрхийг хангах, хуулийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар зогсоох, түүнд нь хүндэтгэлгүй хандах, үйл ажиллагаанд нь хүндрэл учруулах, тэр битгий хэл цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээнээс гадна хүнд ял шийтгэл оногдуулж байгаа явдал бол олон улсын хэмжээнд ямар ч тохиолдолд сэтгүүлчийг аль болохоор хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд аль болохоор Эрүүгийн хуулиар шийтгэхгүй байх. Ийм үндсэн гол зарчим бол олон улсын хэмжээнд явагддаг.

Гэтэл энэ бол Монгол Улсад сүүлийн жилүүдэд бол төвөгтэй байдлаар хэрэгжиж байна. Тийм учраас энэ яахын аргагүй тэр индекс муудахад нөлөөлсөн гэж ингэж үзэж болно. Мөн үүний тод жишээ нь бол Өнөрцэцэг сэтгүүлч бол Хүний эрхийн Үндэсний комисст бол гомдол гаргасан. Энд 2 талаас нь авч үзэх шаардлагатай. Зайлшгүй гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд байгаа бол түүнийг бид Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 22.2-оор тэр үйлдэлд нь бид нар орох ийм хууль зүйн боломжгүй.

Гэхдээ хүний эрх хамгаалагчийн үйлдлийг таслан зогсоосон, тэр хүний хариуцан явуулдаг, эрхлэн явуулдаг хуулийн этгээдийн бүх контентыг бүхэлд нь хааж олон нийтийн мэдэх эрхийг зөрчсөн. Мөн сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчиж байгаа явдал бол хүний эрхийн зөрчил байна гэж Хүний эрхийн Үндэсний комиссоос үзсэн. Магадгүй зөрчилтэй контент байгаа бол тэрийг тодорхой хугацаанд хязгаарлах асуудал л байна уу гэхээс биш бусдыг, бүгдийг нь буруутгаад сэтгүүлчийг тэр чигээр нь харлуулаад тэгээд бас хорих ялаар оногдуулж байгаа явдал бол энэ хүний эрхийн том зөрчил гэж ингэж бид үзсэн.

Хоёрдугаар асуултын хувьд бол Тахарын алба гэж Монгол Улсад байгуулагдаад тодорхой хэмжээнд үйл ажиллагаа явуулаад, түүнийг сайн муу үр дүн нь ямар байгаа вэ гэдгийг үнэлэлгүйгээр төсвийн хувьд төвөгтэй байна, мөнгө төгрөг хүрэхгүй байна гэдэг шалтгаанаар татан буулгасан. Тийм учраас энэ татан буулгасан үйл явдалтай холбогдоод бол олон олон гэрч, хохирогчдын аюулгүй байдал, төвөгтэй байдалд бий болсон. Тэдний хохирлыг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх асуудлууд бол бүүр газарт шалаар унасан.

Тийм учраас өнгөрсөн жил Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн дагуу бид 23 дахь илтгэлдээ бол Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай уялдуулаад хүний эрх хамгаалагчийн аюулгүй байдал, гэрч, хохирогчийн аюулгүй байдал, хохирлын асуудлыг бодитоор шийдвэрлэх энэ асуудлыг иж бүрэн төрөөс хараат бусаар шийдвэрлэх энэ боломжийг хангасан тусгай аюулгүй байдлыг нь хангасан бие даасан механизмтай болох асуудлаар өнгөрсөн жилийн Улсын Их Хурлаас гарсан 35 дугаар тогтоолд тодорхой дурдсан.

Тийм учраас энэ тогтоолыг хэрэгжүүлэх явдал чухал. Үүнд яагаад вэ гэхээр зэрэг гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах асуудал, мөн хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлч, өмгөөлөгч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл, шударга шүүмжлэл өрнүүлсэн иргэд, мөн иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдэд аюултай байдлууд бий болох тохиолдол бол цөөнгүй байна. Тийм учраас эдгээр хүмүүсийн аюулгүй байдлыг хангах асуудал бол Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээр цөөхөн хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа нь бол шаардлага хангахгүй байна.

Хөдөө орон нутагт бол 1 мөрдөгчид хариуцуулж байгаа явдал туйлын хангалтгүй. Энэ бол гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн аюулгүй байдал хөдөө орон нутагт ерөөсөө хэрэгжихгүй байна гэж ингэж үзсэн учраас өнгөрсөн жил бид тодорхой судалгаа хийгээд энэ хараат бус бие даасан механизмыг бий болгох талаар тогтоолд тусгасан. Үүнийг хэрэгжүүлэх асуудал дээр бид бас анхаарч байгаа гэдгийг хэлье.

Б.Баярбаатар: Болчихсон уу? Сунгаад хариулчих.

С.Дондов: Үзэл бодлоо илэрхийлсний төлөө цахим гав хийгээд байж байгаа нь гэртээ хүүхдүүдээ айлгах, ичээх, мөн зарим тохиолдолд тэр нөгөө гавынх нь хугацаа нь дуусах ингээд энэ байдлаасаа болоод тэр цахим гав өөр юугаар өөрчлөгдөх, өөр ялаар солигдох хүртэл ийм төвөгтэй байдлууд бий болж байна.

Тийм учраас энэ дээр бол яахын аргагүй үзэл бодлоо илэрхийлсний төлөө, шударга шүүмжлэл өрнүүлсний төлөө торгох ял өндөр байгаа, тодорхой хэмжээний ялын санкц өндөр байгаа явдал бол зайлшгүй ардчилсан нийгэмд бол тэр дундаа сэтгүүлчид, шударга шүүмжлэл өргөсөн өрнүүлсэн иргэдийн эрх ашгийг

хамгаалахад бол хүндрэл учруулж байна гэсэн ийм ерөнхий саналыг бол бид бас энэ удаагийн илтгэлийн тодорхой сэтгүүлчийн энэ бүлэгт бол бас оруулсан байгаа. Тийм учраас энэ асуудлыг бид цаашид анхааран хэрэгжүүлэх тал дээр бол анхаарна гэж ингэж бодож байгаа.

Мөн хоёрдугаарт өгсөн санал дээр бол энэ Нийтийн ил тод байдлыг нь мэдээлэх тухай хууль төдийлөн сайн хууль юм. Бид нар бас тэр хуулийг бас анхаарч үзэж тодорхой гомдлууд шийдвэрлэх явцад бол хэрэглэж үзлээ. Тэгэхэд бол энэний хэрэгжилт төдийлөн хангалт.../минут дуусав./

Б.Баярбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Аюушийн Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би Хүний эрхийн комисс бас илүү сэдвүүдээ бүр нарийвчилж тухайлсан 1 сэдвээрээ тэгээд маш хатуу чанд, дорвитой арга хэмжээнүүдийг бас хэрэгжүүлдэг байгаасай гэж нэг талдаа санал хэлэх гэсэн юм. Тэгэхгүй хэтэрхий хөвөөд маш өргөн хүрээний асуудлуудыг яриад ирэхлээр аманд ч биш, хамарт ч биш тэгээд л илээд л өнгөрчхөж байгаа ийм асуудлууд байна.

25 дахь илтгэл нь хүүхдийн амьд явах эрхийг бас хөндсөн асуудлаар байгаасай гэж бас саналаа хэлмээр байна. Ер нь бол зөвхөн 23 оны мэдээллийг л аваад үзэхэд амьгүй механик хүчинд өртөж осолд орж эрүүл мэндийн байгууллагад хандсан 9000 хүүхэд, зам тээврийн осолд өртсөн 5000 хүүхэд, түүнээс 51 хүүхэд нас барсан. Хүчирхийллийн шалтгаант бэртэл, гэмтэл аваад 1300, 1400 хүүхэд эрүүл мэндийн байгууллагад хандсан байгаа юм.

Тэгэхээр эцэг эх өөр хүмүүс зодож тийм ээ тухайн хүүхэд гэмтэл аваад эрүүл мэндийн байгууллагад хандсан байна. 0-4 насны 3400 хүүхэд түлэгдсэн байна. 5-9 насны 600, 700 хүүхэд түлэгдсэн байна. 4 жилийн хугацаанд 0-14 насны 12 хүүхэд бас амиа хорлосон байна гэх мэтчилэн тухайн хүүхдийн эрхтэй холбоотой томчууд үүргээ яг хүлээж байна уу, үгүй юү гэдэг дээр бид нар бас маш том анхаарлын тэмдэг тавихгүй бол энэ бэлгийн хүчирхийлэлтэй ч холбоотой эцэг эхчүүдэд нь бид нар ямар ч хариуцлага хүлээлгэхгүй байгаа байхгүй юу.

Гэтэл тухайн эцэг эх хүүхдэдээ үл хайхрах хүчирхийлэлд оруулсан учраас тухайн хүүхэд хэн нэгний бэлгийн хүчирхийлэлд орж байгаа. Ялангуяа 0-6 насны хүүхэд тийм үү? Хүүхдийг хамгаалах энэ асран хамгаалах үүрэг нь эцэг эхэд нь байгаа мөртөөсөө хүүхэд эрсдэлд орлоо гэхэд эцэг эхэд нь ямар ч хариуцлага хүлээлгэхгүй байна. Бид нар Хүүхэд хамгааллын хуульд тухайн архи согтууруулах ундаа нэлээд хэрэглэсэн байгаа бол хүүхдийг та эрсдэлт нөхцөлд оруулж байна шүү гэдэг заалтыг оруулсан гэдгээрээ бараг нийгмээрээ онигоонд оруулаад байсан шүү дээ.

Гэтэл цаад учир шалтгаан нь тухайн хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болоод хүүхдийн хүчирхийлэл нь ямар нөхцөлд хийгдээд байна вэ гэхлээр архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүс дийлэнхдээ энэхүү гэмт хэргийг хийгээд байна гэж. Тэгэхээр энэ хүүхдийг бол яг ийм орчноос хамгаалах нь эцэг эх асран хамгаалагчийн үүрэг том хүн бүрийн үүрэг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас

хэдүүлээ анхаарч энийг нийгэмд дорвитой хүргэх хэрэгцээ шаардлага бол байна гэж.

Хоёр дахь нь болохлоор би бас энэ цахимтай холбоотой бид нар бусад улс оронд яг хэрэгжүүлж байгаа хөгжсөн улс орны энэ зохицуулалтыг Монгол Улсдаа нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байгаа буюу хүн тухайн аккаунтын ард хэн байна вэ гэдгийг тогтоодог буюу тухайн аккаунтыг үүсгэхдээ анхнаасаа тэр регистрийн дугаар байна уу, паспорт байна уу тухайн хүнтэй, иргэнтэй нь өөртэй нь холбодог байхгүй бол энэ хуурамч аккаунт энэ ботууд чинь ердөөсөө үнэхээрийн замбараагаа алдаж байна. Монгол Улсад фэйсбүүкийн хэрэглэгч 6 сая байгаа. Гэтэл хүн ам нь хэд билээ? Түүнээсээ хүүхэд болон настнуудыг хасахлаар хэд байгаа билээ? Аж ахуйн нэгж байгууллага өөрийнхийгөө үүсгэлээ гэсэн ч гэсэн, аккаунт үүсгэлээ гэсэн ч гэсэн цаана нь үнэхээрийн хэтэрсэн маш олон ийм хуурамч аккаунт/ассоунт/-ууд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд зорилго нь юу юм бэ? Энийг яагаад шийдэхгүй байгаа юм бэ гэхлээр магадгүй улс төрчид өөрсдөө өнөөдөр улс төрийн зорилгоор өнөөдөр ч гэсэн яг улс төрийн зорилгоор ашиглаж байгаа хуурамч аккаунт/ассоунт/-ууд байна. Хуурамч аккаунтаар энэхүү үйл ажиллагааг явуулж мөнгө төгрөг олж байгаа хүмүүс ч байна. Хэвлэл мэдээллийнхэн ч энэ дотроо байгааг үгүйсгэхгүй.

Ийм учраас энийг дорвитой шийдвэрлэх арга зам, гарц дорвитой хийхгүй, авч хэрэгжүүлэхгүй арга хэмжээ огт авч хэрэгжүүлэхгүй байгаад үнэхээрийн сэтгэл эмзэглэж байна. Тэгээд энэ зөвхөн энэ улс төрийн агуулгаараа ч өнөөдрийн нөхцөл байдлаас гадна энэ хүүхдүүд гэмт хэрэгт өртөж байгаад үнэхээрийн сэтгэл санаа зовж байна. Тэгэхээр энийг дорвитой Хүний эрхийн комисс бас санаачлан хамтдаа энийг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага бол байна. Цахимыг .../минут дуусав./

Б.Баярбаатар: Хэрлэн гишүүнд микрофон өгье. Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Яг тэгэхээр энэ Хүний эрхийн 2024 оны тайланг ялангуяа бага насны хүүхдэд хүчирхийлэлд өртөж байгаа тухай энэ мэдээллийг сонсоод бас ер нь сэтгэл эмзэглэж сууж байна л даа. Тэгээд сая Хунан даргын яриан дотор бас нэлээн ноцтой тийм дүгнэлтүүд гарч байна шүү дээ. Тухайлах юм бол 40 хүүхдийн материалыг судлаад үзэхэд ердөөсөө 17 хохирлоо барагдуулах хүсэлт гаргасан. 23 барагдуулаагүй. Яагаад гэвэл өмгөөлөгч байхгүй учраас гэж. 17 хүсэлт, хохирлоо барагдуулах хүсэлтийн 7 нь өмгөөлөгч нь санаачилгаараа гаргасан. 10 нь болохоор асран хамгаалагчийн санаачилгаар гарсан гээд. Өөрөөр хэлэх юм бол өөрийнх нь эрх зөрчигдөөд байхад өөрийнхөө эрхийг сэргээх, нөхөн сэргээх, энэ тухай ойлголт бүдэг баадаг байгаатай энэ бас холбоотой юм уу нэг талаасаа.

Нөгөө талаасаа сая өөрийн чинь хэлсэн дүгнэлт дотор гарч байна ердөөсөө энэ Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэж байдаг.

Дээр нь ер нь Хууль зүйн туслалцааны төв гэж бас байгаа тээ? Ер нь хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд бас байгаа. Маш их олон хүн энд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хүмүүс яагаад хүүхдийн эрх тэнд ноцтой зөрчигдөөд байхад хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу тэр хүмүүс яагаад ажлаа гүйцэтгэхгүй байгаа юм бэ? Тэд нарыг гэмт хэрэг гарлаа гэхэд хүүхдийн эрхийг хамгаалах тухай дээр, нөхөн сэргээх тухай дээр хариуцлагатайгаар ажил дүүргийг хийдэг болгох тухай дээр Хүний эрхийн комиссоос ямар шаардлага тавьж байгаа юм?

Тэгээд энэ дээр бид нар энэ төсвийн тухай асуудал ярих гээд л явж байна л даа. Энэ 26 оны төлөвлөгөөний тухай бид нар ингээд л ярих гэж байна. Тэгэхээр энэ байгууллагууд чинь бас л ажлаа хийж байгаа гээд л энэ төлөвлөгөө дотор чинь ороод л ирээд л явж байгаа шүү дээ. Тэгтэл яг хүлээсэн үүргээ гүйцэтгэж хэрэгжүүлэхгүй байгаа ийм тохиолдлууд байгаад байгааг яг холбогдох байгууллагуудад нь хамаатуулж гаргаж ирж тавих, энийг нь иргэдийн өмнөөс шахаж шаардах энэ тухай дээр анхаарах хэрэгтэй байна гэж бодож байна.

Хоёрдугаарт нь бас юу гэж бодсон бэ гэхээр ер нь энэ хүүхдийн эрхийг хамгаалах, хангах тухай асуудал дээр яг урьдчилан сэргийлэх ажлууд дээр бас Хүний эрхийн комиссоос хэрэг гарчихсаны дараа дээр энэ дээр яаж байцаалтыг хийж байна гэдэг тухай асуудлыг ярих, эрхийг нь нөхөн сэргээх тухай асуудлыг ингэж ярихаас илүүтэйгээр урьдчилсан сэргийлэх талын юм руу бас үйл ажиллагаагаа жаахан дорвитой чиглүүлээсэй билээ. Ердөөсөө энэ бага насны хүүхдийн хүчингийн асуудал гэдэг ер нь өмнө нь бай ярьдаг байсан юм уу, байсан юм уу? Одоо яагаад ингэтлээ ингэж их задгайраад байгаа юм тээ? Тэгэхээр энэний цаад учир шалтгааныг нь яг ямар орчин нөхцөлд энэ гэмт хэрэг үйлдэгдээд байгаа юм, хэн үйлдээд байгаа юм? Энэ дээр нарийн сайн судалгаатайгаар урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ тийш нь чиглүүлэх талын юмнуудыг хийвэл яасан юм? Судалгаан дээр суурилагд бүр дорвитой тийм арга хэмжээ авахад үйл ажиллагаагаа чиглүүлээсэй гэж хэлмээр байна.

Б.Баярбаатар: Санал хэллээ. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Гишүүд асуулт асууж үг хэллээ.

Төгсгөлд нь би бас санал хэлчихье. Өнөөдөр бид нар энэ Ёс зүй, дэгийн байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцэж байгаа. Та бүхний танилцуулгад хууль, эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага байна, төсөв мөнгөний бололцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна гэж 2 зүйлийг түлхүү тусгаж байгаа юм. Энэ ёс суртахууны төлөвлөлийг ер нь яаж харж байна? Энэ Хүний эрхийн комисс энэ хүний эрхийн зөрчил гэдэг чинь ерөөсөө ёс суртахууны доголдол байхгүй юу. Ганцхан хууль хяналтын байгууллагын хүрээнд биш, энэ ахуйн орчинд, энэ албан байгууллагын хүрээнд, энэ хувь хүмүүсийн хоорондын харилцаа гээд олон зүйлүүд дээр энэ ёс суртахууны асуудал ярихгүйгээр бид нар энэ мянга хууль, эрх зүйн орчноо сайжруулаад мянга төсөв нэмэгдүүлээд энэ асуудал явахгүй. Өнөөдөр бас мэдээллүүдийг чинь сонсоход сэтгэл сэргийлгэм харамсалтай зүйлүүд нэлээдгүй сонсогдож байна.

Өнөөдөр бид нар энэ Улсын Их Хурал стратеги төлөвлөгөөндөө хүний эрхийг дээдэлсэн хуультай больё гээд гол зорилтоо дэвшүүлээд, хууль хэлэлцүүлгийн түвшинд Хүний эрхийн комисс зөвлөмж зөвлөгөөгөө өгдөг иймэрхүү байдлыг нь, нөхцөлөө эрх зүйн орчныг бүрдүүлээд явж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэлээдгүй манай Үндэсний комисс маань анхаарах зайлшгүй шаардлага байна. Тийм одоо энэ 1 дүгээр асуудал ч тэр, өмгөөлөгч, сэтгүүлчдийн асуудал. Энэ мэргэжлийн ёс зүй хаана явж байна? Бид нар 4 дэх засаглал гээд энэ эрх зүйн чөлөөт хэвлэлийг энэ өндөр түвшинд харж хүндэтгэх ёстой. Нэг талаараа эд нар чинь шүгэл үлээгчид шүү дээ. Энэ эрсдэлээс нь бид нар хамгаалах ёстой. Энэ хууль, хяналтын байгууллагад очоод л өдөржин хууль хяналтын байгууллагын хаалга үүдийг сахиад цахилгаан цээрлүүлэх үйл ажиллагаа хийгээд байгаа чинь энэ чинь өөрөө буруу зүйл байхгүй юу. Гол нь энэ хэвлэл мэдээллийн байгууллага энэ бодитой, үнэн мэдээллийг өгснөө л нотолдог л байх ёстой. Тэгэхээр энэ

аливаа зүйл 2 талтай. Аль аль талыг нь харсан ийм асуудлуудыг энэ зүйл дээр явах ёстой гэж харж байгаа.

Энэ Эрүүдэн шүүх гэдэг асуудал. Ер нь бид нар энэ үгний утгачлалаасаа л авхуулаад л явах ёстой юм байгаа юм л даа. Эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн эрх зүй, эрүү гэдэг үг чинь юу юм? Ер нь яг юу юм? Тэгээд бид нар энэ эрүү гэдэг үгээ ашигласаар байгаа тохиолдолд нь эрүүдэн шүүлтээс яаж татгалзах юм? Тэгээд энэний цаана чинь гэрч, хохирогчийн асуудал байна, мөрдөн байцаагчийн асуудал байна. Олон зүйлүүд байгаа. Мөн л ёс суртахууны мэргэжлийн ёс зүйн асуудал. Өнөөдөр бид нар цаазын ялгүй улс гээд дэлхийд зарлачихсан.

Гэтэл энэ бага насны хүүхдийн хүчирхийллийн асуудлаа хар л даа. Энэ жилд 80 хүүхэд 360 хоногийн 0-6 насны шүү дээ зөвхөн. Дээшээгээ авахгүй байгаа. Тэгээд энэнийх нь 40 гэмт хэргийн 17 нь хохирол барагдуулсан. Нийт 50 сая төгрөг гэж байна. 17-д нь хуваагаад үзэхээр 2.9 сая төгрөг. Энэ бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийллийн хохирол ийм бага хэмжээтэй болчихсон юм уу? Энэ мөнгөн дүнгээр үнэлэх боломжгүй асуудал шүү дээ ер нь бол. Тэгээд энэ соён гэгээрүүлэх ажил чинь ер нь хаана байна? Өнөөдөр энэ бага насны хүүхдэд ийм хандлага гаргаж байгаа энэ сэтгэл зүйн хувьд эмгэгтэй энэ улсуудын асуудлыг ер нь яах юм? Хүний эрх яриад энэ асуудал дээр мэдээж өнөөдөр хүний эрх ярих нь тодорхой. Өнөөдөр гэмт хэрэг үйлдсэн ялтан ч хүн, гэмт хэрэгт холбогдоод байцаагдаж байгаа сэжигтэн ч хүн.

Гэхдээ нөгөө талд нь бас хохирогч хүн гэдгийг бас бодох ёстой шүү. Тэгээд өнөөдөр энэ Хүний эрхийн Үндэсний комисс цаашаа зоригтой ажиллах ёстой, илүү дуугарах ёстой, илүү шүгэл үлээх ёстой та нар яг хариуцаад ажиллаж байгаагийнхаа хувьд. Парламентад энэ хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг дуу хоолойг шууд хүргэдэг байх ёстой. Бид нар чадал чансаа нь юу байдаг юм, хууль, эрх зүйн орчныхоо хүрээнд бүх л түвшинд дэмжиж ажиллана. Гол нь үр дүн. Шаардлагатай бол бид нар үндэсний энэ Хүний эрхийн комиссын эрх зүйн чадамжийг нь нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Тэгж байж бид нар энэ үр дүнг харна.

Дараагийн асуудал ер нь энэ манай Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа учраас ер нь нэг судлах ёстой гол судлагдахуун юу вэ гэвэл энэ Монгол хүн гэж ер нь яг хэн юм бэ, юугаараа онцлог юм, энэ Монгол хүнтэй бид нар ямар байдлаар харилцвал энэ урамшдаг юм, ямар байдлаар харьцвал зөрүүд нь хөдөлдөг юм, хүлээж авдаггүй юм? Энэ тэр гээд энэ ёс суртахуунтай холбоотой энэ хүн судлалын судалгаануудыг бид нар илүү хийж байж энэ дээрээ төвлөрсөн, энэ дээрээ таарсан хууль, эрх зүйн орчныг санаачлаад явах юм. Энэ нь өөрөө илүү их үр дүнтэй болно шүү. Бид нар олон улсын сайн жишиг гээд олон зүйлээс бид нар энэ асуудлуудыг татаж ирээд хуулбарлаад тавьдаг.

Эндээс нь гарч байгаа үр дүн нь хүлээсэн хүлээлтэд нийцдэггүй ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр манай Үндэсний комисс нэлээд анхаарч ажиллаарай гэдгийг би та бүхэндээ хэлье. Дараа дараагийн илтгэлүүдэд энэ өнөөдрийн дурдагдсан энэ тайлан тоонууд илүү үр дүн гарч буурч орж ирэх л үр дүнг л хэдүүлээ хамтдаа л хийе. Та нарын хийх ёстой ажил гээд та нар руу тохоод байж болохгүй. Бүгд л хамтдаа хийж байж л энэ ажил өөрөө үр дүнгээ гаргана л гэж бодож байгаа. Тийм учраас өдөр тутамдаа энэ Их Хурал, парламент, Засгийн газартайгаа хамтарч энэ асуудлуудаа шийдэхэд дэмжлэг,

туслалцаа болж ажиллахын төлөө хэдүүлээ хамтраад ажиллана гэдэг зорилт байна.

Баярлалаа. Ингээд ажлын хэсгийн хүмүүстээ амжилт хүсье. Мэдээллийг сонсож асуулт, хариулт, саналаа хэллээ. Эхний асуудлыг хэлэлцэж дууслаа. Дүгнэлтийг Бадарчийн Хэрлэн гишүүн Хууль зүйн байнгын хороонд танилцуулна. Дараагийн асуудалд орно. Хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилсөн учраас би дараагийн асуудлын ажлын хэсгийг та бүхэнд танилцуулна. Ажлын хэсгээ оруулчих. Дараагийн асуудал.

16.29 цаг

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”, хоёр дахь хэлэлцүүлгийг Ёс зүйн дэгийн Байнгын хорооны хамрах хүрээний түвшинд хийнэ.

Хамрах хүрээний түвшин гэдэг маань өнөөдөр бид нар энэ өглөө бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр яригдсан асуудал байж байгаа энэ төрийн албаны реформ гэдэг асуудал дээр бид өнөөдөр төвлөрч хэлэлцэх ёстой. Төлөвлөгөөнд хийгдсэн реформын түвшинд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог багш, эмч нараас бусад 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ гэсэн ийм реформ байж байна.

Төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарчим, чиг үүргийн хувьд хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлнэ гэсэн ийм 2 заалт байгаад байгаа. Энэ заалтын хүрээнд өнөөдөр манай Байнгын хороо хэлэлцэж дүгнэлт үйлдэх ёстой.

Ажлын хэсэг бэлэн үү? Би ажлын хэсгийг эхнээс нь танилцуулаад явж байя. Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батчулууны Мөнхсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Очиржанцаны Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Зияханы Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Галиндэвийн Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсэг байна. Зарим хүмүүс нь байхгүй байх шиг байна тээ? Ойлгосон.

Би сая үндсэндээ хэлэлцэх хүрээгээ танилцуулчихсан. Ажлын хэсгийг орж ирэхээс өмнө. Танилцуулга хийгдэхгүй шууд гишүүд асуулт асууна. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Бадарчийн Хэрлэн гишүүнээр асуултыг тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би асуулт санал зэрэг явчихъя. Ер нь бид энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиа эргэж харахгүй бол бид нар их үр дүнгүй ажлуудыг их хийгээд байдаг. Нэн ялангуяа яг энэ үр дүнгүй ажлын нь бол яг энэ 1 жилийн хөгжлийн бодлого юм. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний энэ төслийн хэлэлцүүлгийг явуулахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65.1-д зааснаар Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ гэж байгаа юм. Тэгэхээр төсвийн төсөлтэй уялдуулж уг нь хэлэлцэх ёстой. Гэтэл төсвийн төсөл хаа байсан намар л орж ирдэг. Тэгэхээр энэ бол хоорондоо нэгдүгээрт уялдаагүй. Ер нь энэ дунд хугацааны төлөвлөгөө гэдэг нь ч гэсэн ер нь их асуудалтай. Алсын хараа-2050-даа нийцүүлээд 5 жил, 10 жил гэж байгаа бол 5 жил гэж нэг бодлогын бичиг баримт байгаад байдаг.

Гэтэл Засгийн газар сонгуулийн дараа эмхлэн байгуулагдаад дахиад 4 жилийн төлөвлөгөө гээд тусдаа дахиад оруулж ирээд байдаг. Тэгээд хоорондоо тэр нь ердөөсөө нийцдэггүй. Жил жилдээ бас төлөвлөгөө гаргаад байдаг. Өнгөрсөн жилийн төлөвлөгөө жишээлбэл 24 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт нь 52 хувьтай гэж байгаа байхгүй юу. Шал үр дүнгүй. Энэ 21-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг батлахдаа үндсэн чиглэлийг хэмжигдэхүйц хүрч болохуйц, бодитой бус, хариуцах эзэнгүй төлөвлөсөн байна гэдгийг бас ингээд төлөвлөчихсөн байгаа.

Тэгээд анхнаасаа ийм муу бичиг баримт байсан юм бол түүндээ нийцсэн 1 жилийнхэн ч болдоггүй, тэгээд дахиад тусдаа төсөв гэж тусад нь бичиг баримт орж ирдэг. Төсөв дээрээ л яг ёстой жинхэнэ яг юу хэрэгжүүлэх вэ төсөв мөнгөтэй холбоотой арга хэмжээнүүд нь төлөвлөгөөнүүд нь орж ирээд яг бодитой төлөвлөгөө бол ердөөсөө л энэ төсөв байгаад байдаг. Наана нь болохлоор 1 жилийн хөгжлийн төлөвлөгөө гээд ийм үр дүнгүй төсөв гэж буруу ойлгож гишүүд бас хүслийн жагсаалтаа оруулах гээд байдаг. Тэгээд тэр нь эргээд нөгөө яг төсөв хэлэлцэх үед ямар ч шаардлага хангагдаагүй, ямар ч боломжгүй арга хэмжээнүүдийг тусгачихсан байдаг нь эргээд 50-хан хувийн гүйцэтгэлтэй ийм бичиг баримт болоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн энэ хуулиа эргэж харж ядаж дунд хугацааных нь, богино хугацааных нь энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр байгаад түүндээ нийцсэн жил жилийн төсвөө баталдаг байх нь бол өөрөө зүйтэй. Тэгж байж бид нар бас зөв талдаа орно.

Яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой энэ төрийн албан хаагчдын цомхотголтой холбоотой асуулт 1 асууя. Механикаар 9 хувь гэж оруулж ирээд байгааг би ердөөсөө огтоос ойлгохгүй байна. Тэгээд зөвхөн эмч, багш л нэмэгдэж болно, бусад нь нэмэгдэж болохгүй бүгдийг нь хасна гэсэн юм шиг ийм буруу ойлголтыг өгч байгаатай бол би санал нийлэхгүй байна.

Ялангуяа сая бид нар өмнөхөн ярьсан энэ хүүхэд хамгааллын асуудалд бол 9 хувийн.../минут дуусав./

Б.Баярбаатар: Хариултад хариултын 3 номер уу? 3 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Гишүүний асуултад хариулъя. Энэ яг тэгшитгэж яг 9 хувиар бууруулах юм биш ээ гишүүн энэ бид нарын урьдчилсан судалгаагаар юу гэж гарч байгаа гэхээрээ сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчдын тоо өссөн байдаг. Тэгээд төрийн ялангуяа төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувьд барих болон энэ төрийн давхардсан бүтцийг багасгах, мөн энэ цахимжилтын болон Засгийн газар дээр явж байгаа хүний нөөц, ур чадварын шилжилтийн стратеги хийгдэж байгаа гэх мэт ажлуудын хүрээнд энэ төрийн албан хаагчдын тоог бууруулах ийм урьдчилсан судалгаа гарч ирж байгаа.

Энэ судалгааны судалгаа маань тэр төрийн чиг үүргийн шинжилгээг гүйцэд хийж, тэр дахин инженерчлэлийн болон бусад ажлуудыг хийж байж яг аль салбараас хэдэн хувь буурах юм, тэгээд тэр буурч байгаа хүмүүсийнхээ нийгмийн болон бусад асуудлыг яах юм гэдэг тоо нь эцэслэгдэх юм.

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн тодруулна 1 минут.

А.Ариунзаяа: Ер нь төрийн цомхон чадварлаг төртэй байя гэдэг энэ бодлогын зорилт маш олон жил яригдаж байгаа. Төр өөрөө бас хариуцлагатай байж уймраа мартамхай хүн шиг өнөөдөр нэг юм яриад, маргааш өөр нэг юм ярьдаг байж бас болохгүй ээ гэдгийг энэ ташрамд бас протоколд үлдээх гэсэн юм. Тэгээд энэ төрийн албан хаагчдын цомхотголыг хийхдээ бас автоматаар бүгдийг нь 9 хувь гэж хийхгүй гэдэг энэ санал чинь яг үнэн байгаасай. Төсөв орж ирэхэд байгууллагуудад бүгдэд нь бас 9 хувь гээд хүүхэд хамгааллын зардал маань хүртэл төрийн албан хаагчид маань буураад ороод ирэх вий гэдэг дээр үнэхээрийн сэтгэл санаа зовниж байгаа шүү анхаараарай. Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байхад 20 онд л бид нар бас эдийн засгийг сэргээх энэ бас энэ Хэмнэлтийн хуулиар тэтгэвэрт гарсан 2 хүний оронд 1 хүнийг орон тоонуудыг шилжүүлж 1 хүнээр нөхнө өө гэдэг бодлого уг нь баталсан. Тэгээд хэрэгжилт нь ямар байгаа юм. Байхгүй.

Б.Баярбаатар: Хариултыг өгөх боломжгүй байх. Энэ бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрх хэмжээний асуудал асуучих шиг боллоо. Төрийн албаны зөвлөлөөс байгаа юм уу, байхгүй байгаа биз дээ? Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр ямар худлаа хариулттай нь биш. Дараагийн Бадарчийн Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Тэгэхээр төрийн албаны реформын хүрээнд ер нь төрийн албыг бас цомхон, бүтээмжид суурилсан бай байдлаар өөрчлөх ийм том зорилт ороод ирсэн байна л даа. Тэгээд саяын бас яг 9 хувь гэж байна. 8 биш, 7 биш, 10 биш 9 гэж байна тээ? Тэгэхээр энэ 9 гэдэг тоог юунаас үндэслэж гаргасан юм бэ? Тэгэхээр энэ том зорилтыг тавихад өнөөдөр төрийн зарим үйлчилгээнүүдийг цахимаар хүргэж байгаа. Энэ явцад яг цахимаар төрийн үйлчилгээг хүргэх болсонтой холбогдуулаад ямар ямар ажил, үйлчилгээнүүд ер нь их, ер нь ажлын байрыг хэдээр хэмнэх ийм боломж бүрдүүлж байгаа юм. Энийг нарийн судалсан ийм тооцоолол байгаа юу? Энэ тооцоолол дээр үндэслэж энэ 9 гэдэг тоог гаргаж ирэв үү? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, төрийн албан хаагчийг боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад салбарынхыг энэ цомхотголд ерөнхийдөө хамруулна гээд тэгж байна. Тэгээд эндээс ингээд одоо чинь 260 мянга орчим хүнээс чинь юу гэдэг юм 9 хувь нь гэдэг чинь хэд ер нь яг хэд орчим тоогоор бодож байгаа бол? Энэ хүмүүс хөдөлмөрийн зах зээл рүү ингээд шилжлээ гэхэд тэд нарыг ажлын байраар хангах, дахин сургаж бэлтгэх ийм тухайн ажлууд энэ төлөвлөгөөнд ер нь тусгагдах уу? Энэ өөрчлөлтийг нь реформын чинь хүрээнд тусах уу?

Гуравдугаарт нь төрийн албан хаагчдын дундаж нас 38.4 гэж байгаа л даа. Ерөнхийдөө их тийм залуужчихсан байгаа. Тэгэхээр чинь энэ их яг ид хөдөлмөрийн насны баахан олон хүн ажлаасаа чөлөөлөгдөх байдалд ингээд хүрэх нь. Тэгэхээр тэр хүмүүсийн амьдралын баталгааг хангах тухай дээр ажлаас гэнэт халагдсан тохиолдолд өгөх нөгөө мөнгөн урамшууллын тухай асуудлууд чинь эргээд төсөвт чинь ямар хэмжээний ачаалал дарамтыг үүсгэж байгаа вэ? Тэгээд өнөөдөр яах вэ ингээд тоог нь цөөлж байна л даа. Маргааш ахиад өөр газар нь нэмээд аваад явчихдаг ийм талууд байдаг шүү дээ. Тэгэхээр яг энэ шийдвэр дээрээ хэр баттай зогсоно гэж бодож байгаа гэсэн ийм 4 асуултыг би асууя.

Б.Баярбаатар: 3 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Гишүүний асуултад хариулъя. Бид нарын урьдчилсан ингээд судалгаагаар аваад үзэхээр сүүлийн 12 жилийн хугацаанд төрийн улс төрийн алба 36 хувь, төрийн захиргааны алба 31 хувиар өсөж 16 мянгаас 21350 болоод төрийн тусгай алба 28772-49081 болж 70 хувиар, төрийн үйлчилгээний алба 115 мянгаас 152 мянга болж 32.7 хувиар, нийлбэр дүнгээрээ 162769-өөс 24 оны байдлаар 226895 болоод 39 бараг 40 хувь өсчихсөн байгаад байгаа. Нэгдүгээрх нь. Тэгээд энэ сүүлийн хугацаанд өссөн ингэж.

Тэгэхээр үүнээсээ үүдэлтэйгээр бид хэд хэдэн судалгаа хийж үзэж байгаа. Тэгээд тэрний нэг нь болохоороо төрийн чиг үүргийн бүрэн шинжилгээ хийгээд зарим чиг үүргүүдийг хувийн хэвшлээр, мэргэжлийн байгууллагуудаар, төрийн бус байгууллагуудаар, экспертүүдээр хийж гүйцэтгэх боломжтой гэж үзэж байгаа. Зарим төрийн албан хаагчид магадгүй гараад, төрийн албанаасаа гараад тэр чиг үүргийг үргэлжлүүлж явахыг үгүйсгэхгүй. Мөн хөдөлмөрийн зах зээл дээр бас энэ томоохон төсөл, мега төслүүд болон арга хэмжээнүүдэд хэрэгжиж байгаа.

Дээрээс нь Ерөнхий сайдын албан даалгавар гараад энэ жилдээ бид нар юуг хийж дуусгах вэ гэхээрээ 3 шилжилт хиймэл оюун, нөгөөдөх хоёр дахь нь болохоороо хөтөлбөрийн зах зээл, ур чадварын шилжилт. Тэгээд энэ хүрээндээ бид хүний нөөцийн стратегийг гаргаж авна гэж тооцож байгаа. Гурав дахь нь ногоон хөгжил гээд. Энэ маань энэ төрийн албаны цомхон, бүтээмжтэй чиглэл рүү явж байгаа багц цогц арга хэмжээний нэг хэсэг нь юм. Ахиад хэлэхэд бид нарт урьдчилсан судалгаанууд байгаа. Яг аль албанаас нь яаж явах вэ гэдэг нь түрүүний ярьсан хэд хэдэн судалгаа, энэ Улсын Их Хурал дээр энэ бодлогын баримт бичиг маань батлагдвал үргэлжилж байж 26 оны яг эхлэхээс нь өмнө нарийвчилсан яг аль салбараас яах юм тэгээд тэр чинь ахиад энэ чинь цогцоороо болохоороо нэлээд ажлууд ихтэй юм байна лээ. Тэр халагдах, цомхотгол орох тохиолдолд тэр хүмүүсийнхээ дараагийнхаа ур чадварынхаа сургалт энэ тэр яах вэ гэх мэтчилнээр ажлууд нэлээн хийгдэх юм байна лээ. Товч хариулахад тийм байна гишүүн ээ.

Б.Баярбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлэх гишүүд байна уу?

Үг хэлэх гишүүд кнопоо дар. Дүгэрийн Рэгдэл гишүүнээр тасаллаа. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Төрийн албаны реформ хийх асуудал төрийн албаны ажиллагсдын орон тоо нэмэгдээд байгаатай холбоотой гэж л ойлгогдож байгаа энэ жилийн энэ 26 оны улсын төлөвлөгөөнөөс. Гэтэл энэ чинь төрийн алба, төрийн үйлчилгээ дээр энэ угаасаа аяндаа нэмэгдээд явчихдаг. Тэгэхээр та нарт судалгаа байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна. Хамгийн их нэмэгдэж байгаагаар миний ажиглаж байгаагаар энэ төрийн захиргаан дээр байна. Яагаад вэ гэх дээр зэрэг сүүлийн үед бараг Улсын Их Хурлын тогтоолоор агентлаг байгуулдаг болж байгаа. 24 оноос хойш аваад үзэхэд 5, 6 агентлаг байгуулаад хаячхаж байгаа юм.

Гэтэл агентлагийн хажуугаар баахан чиг үүргийн давхардлыг ингээд хариуцаж байна гээд хороо, зөвлөл гээд Засгийн газрын, Ерөнхий сайдын хавьцаа ингээд баахан юм байгуулчихдаг. Одоо хамгийн сүүлчийн ганц жишээг хэлэхэд Ургамал хамгааллын агентлаг гээд байгууллаа. Гэтэл Монгол Улсад Ургамал хамгааллын хүрээлэн гээд байж л байгаа юм л даа. Тэр энэ Ургамал хамгааллын агентлагийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх хэмжээний 100 гаруй эрдэм, шинжилгээний ажилтантай ийм хүрээлэн. Гэтэл яагаад Засгийн газрын зарим чиг үүргийг тэр хүрээлэнд хариуцуулаад явж болдоггүй ингээд агентлаг байгаад байгдаг юм?

Ер нь сүүлийн үед ингээд хууль дагуулаад агентлаг байгуулаад байдаг. Тэгээд л хуульд нэр заачихсан. Тэгээд л дараа нь байгуулчихдаг. Энэ үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр та бүхэнд хийж байгаа судалгаа, тодорхой санал, онол байна уу? Би Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас л асуумаар байгаа юм л даа. Тэгэхээр хүн алга учраас Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууж байгаа юм.

Хоёрдугаарт энэ төлөвлөгөөнд төрийн албаны реформын хүрээнд ТӨК-удын реформыг эрчимжүүлээд зардлыг нь 15 хувь бууруулчихаад бүтээмжийг нь 30 хувь нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Энэ их том нөөцийг зардал 15 хувь буугаад бүтээмж 25, 30 хувь нэмнэ гэхгэхээр энд их нууц том нөөц байсан байна л гэж бодоод байна л даа. Энэ ямар үндсэн дээр ийм тодорхой тоо яриад байгаа юм бэ? Энэ чинь ТӨК-уд, ТӨҮГ-уудын засаглалыг сайжруулах асуудал чинь нэг хэсэг сүрхий эрчимтэй яваад, бараг хууль гаргаад, ингээд л хуулиар зохицуулаад л засаглалыг нь жигтэйхэн сайн болгоод л ингээд л явчих юм байх гэсэн чинь таг чиг болж байснаа энд тэнд баахан менежерүүд хяналтын, бүтээмжийн гэсэн тодотголтой, орлогч даргын зиндааны менежерүүд тавиад бүр эсрэгээрээ юм болоод явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ ямар бодлого, энэ улсын төлөвлөгөөг чинь хэрэгжүүлэхэд энэ ер нь ямар хэрэгтэй юм байдаг юм гээд би бас гайхаад л байгаа.

Гуравдугаарт бол ер нь түрүүн Ариунзаяа гишүүн бас хэлчихлээ одоо бид нар Их Хурлаар хэлэлцэж яваад 26 оны улсын хөгжлийн төлөвлөгөө баталчих л байлгүй. Ямар хэмжээний өөрчлөлт орвол орох байх. Гэтэл энэ маань 26 оны улсын төсөл батлагдаад гараад ирэхэд тэрэнтэйгээ зөрчил үүсээд ирвэл энэ төлөвлөгөөг эргэж харах талаар та бүхэн маань бас юм бодож байхгүй болохгүй

байх шүү. Зүгээр хаячихвал төлөвлөгөө маань цаас, төсөв маань хэрэгжээд ингээд явчих л юм болно. Дараа нь төлөвлөгөөний биелэлт гарна. Сая гарч ирж байна шүү дээ 24 оны улсын төлөвлөгөөний биелэлт 52.7 хувьтай байна гээд л. Энэ чинь юу гэсэн үг вэ? Жирийн байгууллага бараг тараад уначихмаар л юм байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр бас санаа оноогоо эртнээс бэлдэж байгаарай гэж хэлмээр байна.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Гишүүд санал хэлж дууслаа.

Өглөө Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас энэ асуудал хэлэлцэгдээд явсан. Би бас нэлээдгүй шүүмжлэлтэй хандаж байгаа энэ асуудал дээр. Тоон дээрээ би бүүр лавлаж үзсэн. Өнөөдөр багш, эмч нараас гадна 73 мянган төрийн албан хаагч байна. Энэний 9 хувь гэхээр бараг 7 мянган төрийн албан хаагч. Тэгээд энэ 26 онд энэ тооны хэмжээний төрийн албан хаагч ажлаасаа чөлөөлөгдөх юм байна. Энэ төлөвлөгөө хэрэгжих ёстой. Бид нар баталсан тохиолдолд хэрэгжүүлэхийн тулд ажиллана.

Тэгэхдээ өнөөдөр энэ төрийн албаны энэ төрийн албан хаагчийг цомхотгоно гэдэг асуудлаа өнөөдөр нэгдүгээрт би шууд хэлье. Байгууллагууд руу шууд тэдэн тонны квот өгөөд танай байгууллагаас тэдэн хүн цомхотго гэдэг байдлаар асуудалд хандаж болохгүй шүү. Болохгүй шүү. Энэ тусгаар улс гэдэг чинь төртэй байдаг юм. Төр нь төрийн албан хаагчтай байдаг юм. Төрийн албан хаагч нь төрдөө үйлчилдэг юм. Төр нь төрийн албан хаагчаа нийгмийн баталгааг нь хангадаг юм. Энэний цаад агуулга нь өөрөө энэ төрд итгэх итгэлийн асуудал байгаа шүү. Тэгээд өнөөдөр үнэхээр энэ эдийн засгийн хувьд хэмнэх гээд байгаа энэ урсгал зардлуудаа хэмнэ л дээ. Заавал 1 хүнийг амьдралаас нь салгаж яах гэсэн юм та нар ийм төлөвлөгөө оруулж ирж?

Хоёрдугаар асуудал нь ерөнхий ийм цогцоор нь асуудалд хандъя гэдэг байдлаар асуудлаа байж ярьж явах ёстой байтал энд тэндээс шүд сугалж байгаа юм шиг ийм төлөвлөгөө оруулж ирээд байх юм. Тэгээд энэний чинь дараа нь иймэрхүү байдлаар ийм төлөвлөгөө боловсруулж ороод ирэхээр дараа дараагийн үр дүнгүүд нь 50 байтугай хувь руугаа доошоо буугаад орно шүү дээ. Энэ чинь хэрэгжихгүй шүү дээ. Тэгээд хэрэгжихгүй юмыг бид нар энд хэлэлцэж цагаа үрээд бас яах юм. Тэгэхээр эдгээр зүйлүүдийг энэ бодох ёстой. Энэ олон дарга нараа цөөл. Энэ түр орлон гүйцэтгэгч нараараа цөөл. Дарга л болохгүй бол ажил хийж болохгүй байгаа цаг үед амьдраад байгаа юм шиг ийм нөхцөл байдал тулгамдаад байгаа шүү. Тэгэхээр энэ Эдийн засаг, хөгжлийн яам үнэхээр энэ эдийн засгийнхаа хувьд энэ зардал хэмнэлт, асуудал юмнууд дээр хандаж байгаа бол хүн ажлаас чөлөөлөх биш данхар бүтцээ бууруул тэгвэл. Давхацсан өгөгдлөө өнөөдөр ганцхан тохиолдолд төрийн албан хаагчийг чөлөөлж болно шүү дээ. Тэр ерөөсөө аттестатчилал явуулах байхгүй юу. Чадамжийн асуудал дээр л тулна. Өнөөдөр төрийн албанд тэнцэж байна уу, үгүй юу гэдгийг л тэр тодорхой хугацаанд аттестатчилал хийдэг л байх ёстой байхгүй юу. Тэрэнтэй тэнцэхгүй байгаа тохиолдолд тэр асуудлыг үнэхээр ярьж болно. Тэгэхээр энэ дээр манай ажлын хэсгийнхэн их анхаарч ажиллаарай. Дараа жилийн өдийд хэдүүлээ дахиад л уулзана. Өнөөдрийн энэ төлөвлөгөөнийхөө гүйцэтгэлийг яриад л дахиад л уулзана. Тэр үед хэдүүлээ бас үр дүнтэй байж баймаар байна. Зөв үр дүнтэй шүү тэгэхдээ буруу биш. Энэ дээр манай ажлын хэсэг анхаараарай гэж хэлье.

Зарчмын зөрүүтэй санал манай Байнгын хороон дээр гараагүй учраас санал хураалт явагдахгүй. Мөн хэлэлцэж байгаа холбогдолтой асуудалтайгаар бас хоёр

дахь хэлэлцүүлэг учраас санал хураалт явагдахгүй. Ингээд ажлын хэсгийн гишүүдээ баярлалаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэн овогтой Жаргалсайхан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооныхоо гишүүдэд талархал илэрхийлье. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

16.52 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР